

ГАРЧИГ

2 ББСБ-ууд 2019 онд хувь нийлүүлсэн хөрөнгөө 1.4 тэрбум төгрөгт хүргэнэ

3–6 Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийг тогтоосон олон улсын туршлага

8–9 Н.Хүдэрчулуун: Шийдвэр хэрэгжиж эхлэхээс өмнө 4.2 хувь байсан хүүгийн түвшин өнөөдөр 3.3 хувь болж буурсан

9 “Үнэт цаас барьцаалах тухай журам”

11–13 Олон улсын туршлага – Рэгтек

13–15 Иргэдийн санхүүгийн байдал ба санхүүгийн зах зээлийн талаарх мэдлэг, итгэлийг тандах судалгаа

16 Хадгаламж, зээлийн хоршоодын холбоо

18 Азийн санхүүгийн байгууллагын форум 2019

20–21 Б.Лхагвасүрэн: Хувьцааны үнэ хэлбэлзэлтэй байх нь хөрөнгө оруулагчдад ашигтай

21 2018 оны жилийн эцсийн тойм

24 2019 оны үйл явдал

Б.Лхагвасүрэн:

ХУВЬЦААНЫ ҮНЭ ХЭЛБЭЛЗЭЛТЭЙ БАЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД АШИГТАЙ



Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Лхагвасүрэнтэй ярилцлаа.

–Банк бус санхүүгийн байгууллага олон нийтээс хөрөнгө татаж нээлттэй хувьцаат компани болж байна. Эдийн засагт нөлөөлөх өгөөжийг тайлбарлаж өгөхгүй юү?

–Өнөөдөр Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн сарын хүү 3–3.5 хувийн хүүтэй. жилийн 36–42 хувийн хүүтэй байгаа. Гэхдээ иргэн, аж ахуйн нэгж хэзээ ч банк бусаас

банкнаас авдаг шиг жилийн хугацаатай зээл авдаггүй. Яагаад гэхээр тухайн хүний санхүүгийн хэрэгцээг хангаж буй богино хугацааны эргэлтийн хөрөнгийн зээл учраас тэр. Өөрөөр хэлбэл, иргэн, аж ахуйн нэгж импортоор бизнес хийе гэхэд 500 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хэрэгтэй бол хурдан хугацаанд сар эсвэл хоёр сарын хугацаанд борлуулаад банк бусаас авсан зээлээ эргүүлээд төлөх л асуудал.

Энэ бизнесээ ойролцоогоор 25 хувийн ашигтай гэж тооцоход хоёр сарын хугацаатай зээл авахад долоон хувийн хүүтэй зээлнэ. Зардал нь долоон хувь, ашиг нь 18 хувьтай бизнес хийсэн гэсэн үг. Банкнаас тавьдаг шалгуур, судалгааг авч үзэхгүйгээр бизнест нь анализ хийж үзээд өгдгөөрөө онцлогтой. Хүмүүсийн санхүү, бизнесийн хэрэгцээг богино хугацаанд шийдвэрлэх зах зээлийн эрэлт байгааг харгалзан төрөөс үүнийг хяналттайгаар зохицуулах үүднээс манай байгууллагаас ББСБ-ын тусгай зөвшөөрлийг олгодог.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ 2,511.8 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРЧ ӨНГӨРСӨН ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД 2.9 ХУВИАР ӨСЛӨӨ

2018 оны жилийн эцсийн байдлаар Монголын хөрөнгийн зах зээлд Үнэт цаасны арилжаа эрхлэх 2, төлбөр тооцооны 1, төвлөрсөн хадгаламжийн 1 байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн 17 компани, 12 хувийн хөрөнгө оруулалтын сан, 3 кастодиан банк, 54 үнэт цаасны компани тус тус үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Хороонд бүртгэлтэй нийт 305 хувьцаат компани байна.

Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,511.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 71.5 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт ЗЗҮ-г 2018 оны жилийн эцсийн ДНБ-д харьцуулахад 7.8 хувьтай тэнцэж байна. Тайлант онд өссөн дүнгээр нийт 210.3 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж хөрвөх чадвар өнгөрсөн оноос 5.2 пунктээр өсөж 8.4 хувьд хүрлээ.

2018 оны 4 дүгээр улирлын байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “Монголын үнэт цаасны бирж” ХХК-аар дамжуулан нийт 245.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь түүхэн дэх хамгийн өндөр дүн бүхий арилжаа болсон юм. Нийт арилжааны дүнг задлан авч үзвэл, МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 31.4 төгрөгийн хувьцаа, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 178.6 тэрбум төгрөгийн хувьцаа, 33.5 тэрбум төгрөгийн ЗГҮЦ, 631.6 сая төгрөгийн компанийн бонд, МҮЦБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 1.0 тэрбум төгрөгийн компанийн бонд, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 292.1 сая төгрөгийн хувьцаа, 66 сая төгрөгийн бондыг тус тус арилжаалав.

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, үр чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хороо товхимол

📍 Монгол Улс, Улаанбаатар хот 15160 Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын IV байр.

☎ 976 51 261611

✉ press@frc.mn

🌐 www.frc.gov.mn

📍 Санхүүгийн зохицуулах хороо

📍 @FRC_of_Mongolia

Хэвлэл мэдээллийн алба

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ББСБ-УУД 2019 ОНД ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨӨ 1.4 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРГЭНЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн байгууллагын салбарт хэрэгжүүлж буй чадавхжуулах бодлогын хэрэгжилт өнгөрөгч 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 95 хувьтай байна. Энэхүү чадавхжуулах бодлого 2021 он хүртэл үе шаттай хэрэгжих бөгөөд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-ууд 2019 онд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 1.4 тэрбум төгрөгт хүргэх шаардлагатай.

ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ, ЗААВАР, АРГАЧЛАЛЫГ МӨРДҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо гүйцэтгэлд суурилсан хяналт шалгалтаас эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо руу шилжихээр холбогдох бодлогын баримт бичгүүдийг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөж эхлээд байна. Үүний хүрээнд даатгалын салбарын “Эрсдэлд суурилсан хөрөнгө тооцох аргачлал”, “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хэрэгжүүлэх журам” болон “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ыг батлан, 2019 оны нэгдүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдүүлж эхэллээ. Эдгээр журам, заавар, аргачлалыг мөрдүүлснээр даатгалын зах зээлийн оролцогчдын эрсдэлийг тооцох, удирдах тогтолцоо бүрдэх юм.

ШИНЭЭР ГАРГАХ ХУВЬЦААГ БҮРТГЭЖ, БАГЦ ДҮРМҮҮДИЙГ БАТАЛЛАА

Санхүүгийн зохицуулах хороо 2019 оны анхны ээлжит хуралдаанаараа Даатгалын болон Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрмүүдийг хэлэлцэн баталлаа. Даатгалын багц дүрэмд тусгай зөвшөөрлийн, нөхцөл шаардлага, шалгуур үзүүлэлтийн, төлбөрийн чадварын, нөөцийн болон бусад сангийн, ил тод байдал, тайлагналын, хяналтын, хариуцлагын зэрэг 17 дүрэм, журам, аргачлал, заавар багтаж байгаа бол Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм нийт 14 зохицуулалтын актаас бүрдэж байна. Эдгээр багц дүрмүүдээр даатгалын болон үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагааг эрхэлж буй хуулийн этгээдүүдэд

тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох, бүртгэх, үүнтэй холбогдон тэдгээрт тавигдах шаардлага, шалгуурыг тогтоох, үйл ажиллагаанд тавих, дагаж мөрдөгдөх хяналт, зохицуулалт, мөн тэдгээрийн дотоод үйл ажиллагаа, мэдээлэл, тайлагналын асуудал, татан буулгах дахин хөрөнгөжүүлэх болон зар сурталчилгаанд тавих хяналт зэрэг цогц харилцааг нийтэд нь зохицуулах юм.

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИТХТ-ИЙН ДАРГА, ЗАСАГ ДАРГА НАРТ ТАНИЛЦУУЛГА ХИЙЛЭЭ

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг тэлж, хаана амьдарч байгаагаасаа үл хамааран иргэд өөрт тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хямд, шуурхай, сонголттойгоор хүртэх боломжийг өсгөх нь Хорооны бодлогын гол зорилт болохыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид (ИТХТ)-ийн дарга, Засаг дарга нарын нэгдсэн семинарт хийсэн танилцуулгадаа онцоллоо.

Тэрээр нутгийн удирдлагын тэргүүн нарт зориулан “Санхүүгийн зах зээл, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт илтгэлийг тусгайлан бэлтгэж, үүндээ орон нутагт үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр Хорооноос явуулж буй бодлогын зохицуулалтууд, ялангуяа сүүлийн жилүүдэд ихээхэн идэвхжиж буй хөрөнгийн зах зээлд орон нутгийн аж ахуйн нэгжүүд болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар гарч буй нааштай үр дүнгүүдийн талаар танилцуулав.

ХОРОО, МОНГОЛБАНКНЫ ХАМТАРСАН ШАЛГАЛТ ЭХЭЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар нэр бүхий томоохон 46 компанид газар дээрх хяналт шалгалт хийж эхлүүлэв. Хяналт шалгалтаар дээрх компаниудад Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт ямар байгаа, дотоод хяналтын хөтөлбөрөө бүтцийн байгууллагууд буюу охин компаниуд, хамаарал бүхий нэгжүүддээ хэрхэн хэрэгжүүлж байгааг нягталж, тэдгээрийн үйл ажиллагааны болон санхүүгийн харилцаа хамаарал, мөн санхүүгийн гэмт хэрэгт өртөх



эрсдэлийг тодорхойлох юм.

Тус хяналт шалгалтын хүрээнд тухайн компаниудад эрсдэлээс хамгаалах тогтолцоо бүрдсэн эсэх, харилцагчдаа танин мэдэж, эцсийн өмчлөгч болон нөлөө бүхий этгээдийг тогтоож чадаж байгаа эсэх, мөн НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн хоригуудыг хэрэгжүүлэх талаар авч буй арга хэмжээ, албан хаагчдын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох эрх зүйн зохицуулалтуудын талаарх ойлголт, мэдлэг, сургалтад хамрагдсан байдал зэрэг өргөн хүрээний асуудлыг газар дээр нь хянан шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх юм.

ХЗХ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН БОЛОН ГИШҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХ ҮҮРЭГТЭЙ

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль болон холбогдох журам, дүрэмд заасны дагуу хоршоо (ХЗХ)-д өөрийн хөрөнгийн хэмжээ, түүнд гарсан өөрчлөлтийн талаарх мэдээллийг хагас болон бүтэн жил тутам Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж байх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдэхдээ Хорооноос тогтоосон нягтлан бодох бүртгэлийн журам, маягтын дагуу тайлагнана.

ХЗХ-ны өөрийн хөрөнгөд гишүүний болон идэвхигүй гишүүний оруулсан хувь хөрөнгө, дахин үнэлгээний нэмэгдэл, нөөцийн сан


болон бусад сангууд, хандив тусламж, хуримтлагдсан орлого зэрэг хамаардаг. Өөрийн хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээлэл, бүртгэл нь санхүүгийн тайлангийн бүрдэл хэсэг бөгөөд гишүүдийн тоонд орсон өөрчлөлт мөн түүний бүрэлдэхүүн юм. Иймд ХЗХ тухайн жилийн эцсийн байдлаарх хувь нийлүүлсэн хөрөнгө болон гишүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг гишүүн тус бүрээр өөрийн хөрөнгийн тайланд нэг бүрчлэн тусгах шаардлагатай юм.

ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРЛИЙГ БУУРУУЛАХ БОДЛОГО БАРИМТАЛЖ БАЙНА

Хувьцааны зах зээл дээр төвлөрөл хэт өндөр байх нь ихээхэн сөрөг талтай. Энэ нь хувьцааны ихэнх цөөн тооны том хувьцаа эзэмшигчийн мэдэлд байна гэсэн үг юм.

Манай улсын хувьцааны зах зээл хэт төвлөрөлтэй, хувьцааны хөрвөх чадвар тааруу, улмаар жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөх эрсдэл бүхий шинж чанартай болоод багагүй хугацаа өнгөрч буй. Энэ нь эргээд зах зээлийн нэр хүндэд муугаар нөлөөлж, шинээр орж ирэх хөрөнгө оруулагчдын урсгалыг сааруулдаг. Иймд Санхүүгийн зохицуулах хороо төвлөрлийг цаашид нэмэгдүүлэхгүй байх, улмаар багасгах бодлогыг түлхүү баримталж байна.

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааг 1072 ширхэгээр эзэмшүүлсэнтэй холбоотойгоор иргэд үнэт цаасны дансаа шинээр нээлгэх нь эрс идэвхжиж байна. 2018 оны байдлаар үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид шинээр 398,255 данс нээгдсэн нь өмнөх оны мөн үеэс 20 дахин нэмэгдсэн дүн юм.




БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ ТОГТООСОН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг банк бус санхүүгийн байгууллага нь хөгжиж буй орнуудад банкны үйлчилгээ хүрэхгүй байгаа орон зайг нөхөж ажилладаг. Нөгөө талаасаа мэдээллийн ил тод байдал, зохицуулалтын орчин сул улс орнуудад эдгээр байгууллагууд сүүдрийн банк хэлбэрээр ажиллаж санхүүгийн зах зээлийг системийн эрсдэлд оруулах магадлалыг нэмэгдүүлдэг.

Монгол улсын банк бус санхүүгийн байгууллагын тоо сүүлийн жилүүдэд огцом өсөж байгаа нь санхүүгийн зах зээлд эрсдэл дагуулах хандлагатай байсан тул Камбож, Бангладеш, Гана, Энэтхэг, Пакистан, Вьетнам зэрэг улсуудын бичил санхүүгийн зах зээлийн зохицуулалт, тэр дундаа банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хэрхэн тогтоосон талаарх туршлагыг судлав.

1. КАМБОЖИЙН ВАНТ УЛС



Бичил санхүүгийн зах зээл: Камбож улсын бичил санхүүгийн зах зээл нь хадгаламж зээлийн хоршоо болон банк бус санхүүгийн байгууллага гэсэн 2 төрлийн байгууллагуудад хуваагддаг ба нийт 54 банк бус санхүүгийн байгууллага, 7 хадгаламж зээлийн хоршоо үйл ажиллагаа явуулж байна.

Зээлийн сарын хүү: Риел (KHR) 3.2 хувь, ам.доллар 2.4 хувь, бусад валютын зээл 3.1 хувь

Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт: 2016 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн тогтоолоор Камбож улсын төв банк арилжааны банкууд болон бусад санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2018 оны 3 дугаар сар гэхэд өсгөсөн байх шийдвэр гаргав. Хадгаламжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2.5 сая ам.доллараас 30 сая ам.доллар болгон нэмэгдүүлж, банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 62,500 ам.доллараас 1.5 сая ам.доллар болгон нэмэгдүүлэв.

Камбож Улсын Төв Банкны ерөнхий захирал Чи Сэрэй хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх болсон шийдвэрээ тайлбарлахдаа: “Банкуудыг эрсдэлгүй, найдвартай үйл ажиллагаа явуулахад мөн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн” хэмээн The Phnom Penh Post-д мэдэгджээ.

2. БҮГД НАЙРАМДАХ БАНГЛАДЕШ АРД УЛС

Бичил санхүүгийн зах зээл: Бангладеш улсад нийт 32 банк бус

санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрээс 3 нь засгийн газрын эзэмшилд, 10 нь хамтын хөрөнгө оруулалтаас бүрдэж, харин 19 нь хувийн эзэмшилд багтаж байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгө 2015 онд 563.8 тэрбум така буюу 7.1 тэрбум ам.доллартой тэнцжээ.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт: Бангладеш улс банк, банк бус санхүүгийн байгууллагын салбарыг чадавхжуулах үүднээс 2003, 2009, 2011 онуудад хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг удаа дараа нэмэгдүүлж байв. Төв банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, Базел II стандартыг хэрэгжүүлэх зорилгоор 2011 оны 7 дугаар сард банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 1 тэрбум така буюу 12.7 сая ам.доллар болгон нэмэгдүүлэх шаардлагыг тавьсан юм. Төв Банк уг шаардлагыг биелүүлэхэд банк бус санхүүгийн байгууллагуудад тодорхой хугацаа шаардлагатай гэж үзэж хувь нийлүүлсэн хөрөнгийг шат дараатайгаар нэмэгдүүлэх шийдвэр гаргасан ба заасан хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлагыг биелүүлээгүй банк бус санхүүгийн байгууллагуудыг хооронд нь нэгтгэх арга хэмжээ авах шийдвэр гаргажээ.

3. БҮГД НАЙРАМДАХ ГАНА УЛС




Бичил санхүүгийн зах зээл: Гана улсын санхүүгийн салбар нь “Formal” буюу албан ёсны, “Semi-formal” буюу хагас албан ёсны, “Informal” буюу албан ёсны бус гэсэн 3 дэд салбаруудад хуваагддаг. Албан ёсны салбар нь арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагууд,

хөдөө орон нутгийн банкууд, болон хадгаламж зээлийн компаниудаас бүрддэг.

2016 оны 1 дүгээр сарын байдлаар Гана улсад нийт 66 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт: Банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 7 сая седи буюу 1.7 сая ам.доллар байсан бол 2013 онд 15 сая гана седи буюу 3.5 сая ам доллар болгон өсгөжээ. Учир нь 2012 оны 12 дугаар сард нийт бичил санхүүгийн байгууллагуудын тоо 90 байсан нь 2013 оны 6 дугаар сард 228 болж огцом өссөн ба маш олон тооны жижиг бичил санхүүгийн байгууллагууд байгуулагдах болов. Иймд банкнаас бусад санхүүгийн салбарыг эрсдэлээс хамгаалах үүднээс хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөсөн байна. Хэдий Гана улсын төв банк хувь нийлүүлсэн хөрөнгийг 2 дахин өсгөсөн боловч, зарим эдийн засагчид хувь нийлүүлсэн хөрөнгийг хангалттай хэмжээнд өсгөөгүй, салбарыг эрсдэлээс хамгаалахын тулд дахин өсгөх шаардлагатай гэж үзэж байв.

4. БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС



Бичил санхүүгийн зах зээл: Энэтхэгийн нөөцийн банкны мэдээлснээр 2014 онд нийт 36,347 банк бус санхүүгийн байгууллага бүртгэгджээ. Харин эдгээрээс 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 11,363 банк бус санхүүгийн байгууллага хадгаламжийн бус үйл ажиллагаа, 187 банк бус санхүүгийн байгууллага хадгаламжийн үйл ажиллагаа, 71 банк бус санхүүгийн


байгууллага бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа явуулж байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын ДНБ-д эзлэх нийт хөрөнгийн хэмжээ 2006 онд 8.4 хувь байсан бол 2013 онд огцом өсөж 12.5 хувьд хүрчээ.

Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлийн жилийн дундаж өсөлт 2007-оос 2013 онд 24.3 хувь байсан бол банкных 21.4 хувь байв. Өөрөөр хэлбэл банкны сектороос илүүтэйгээр банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээл хурдтай өсөж байсан. Банк бус санхүүгийн байгууллагууд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэн, эдийн засаг дахь үр ашигтай салбаруудын зээлийн хэрэгцээг хангах болов. Ийнхүү санхүүгийн салбарын бусад аж ахуйн нэгжүүдтэй хэт хамааралтай болсон нь эрсдэлүүдийг өсгөх болсон. Тухайлбал нэг талдаа дампуурал, хүүгийн түвшний хэлбэлзэл зэрэг хөрөнгө талын эрсдэл, нөгөө талдаа хөрвөх чадвар, төлбөрийн чадвар зэрэг өр төлбөр талын эрсдэлийг дагуулж байв. Иймд Энэтхэгийн нөөцийн банк 2014 оны 11 дүгээр сард хууль, эрх

зүйн зохицуулалтдаа өөрчлөлт оруулсан ба үүнд хөрөнгийн зохистой харьцааг өсгөх шийдвэр багтаж байв.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт: 1999 оны 4 дүгээр сараас өмнө байгуулагдсан байгууллагуудын цэвэр эзэмшлийн сан 2.5 сая рупи буюу 37 мянган ам.доллар байсныг үе шаттайгаар 2017 он гэхэд 20 сая рупи буюу 294 мянган ам.доллар буюу 8 дахин өсгөхөөр баталжээ. Кэй Пи Эм Жи олон улсын аудитын байгууллага энэхүү арга хэмжээнд дараах дүгнэлтийг гаргасан байна. “Ийнхүү хөрөнгийн шаардлагыг өсгөх нь ил тод байдлыг нэмэгдүүлэх, салбарыг хөрөнгөжүүлэх, дотоод болон гадаад шокийн эрсдэлд тэсвэртэй болгох, эдийн засаг дахь хүчтэй тоглогчид руу төвлөрөх давуу талуудыг бий болгох юм. Түүнчлэн энэ нь ашигт байдалд нөлөөлөх талтай бөгөөд урт хугацаандаа банк бус санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулж, чанаржуулах боломжийг бүрдүүлнэ. Цаашлаад компанийн засаглал сайжирснаар салбарын хөгжилд чухал нөлөөтэй.”

5. ИСЛАМЫН БҮГД НАЙРАМДАХ ПАКИСТАН УЛС



Бичил санхүүгийн зах зээл: Пакистан улсын санхүүгийн зах зээл нь банк ба банкны бус санхүүгийн байгууллагуудаас бүрддэг. Харин банкны бус санхүүгийн байгууллага нь хөрөнгө оруулалтын банк, хөгжлийн банк, бичил санхүүгийн банк, Исламын банк, даатгалын компани, хөрөнгийн зах зээл, түрээсийн компани, хамтын сангууд орно. Пакистан улсын бичил санхүүгийн зах зээл нь бичил санхүүгийн банк, бичил санхүүгийн институт болон хөдөө, орон нутгийн санхүүгийн үйлчилгээг дэмжих хөтөлбөр гэсэн 3 төрөлтэй бөгөөд нийт 7 банк бус санхүүгийн байгууллага 289 салбартайгаар үйл ажиллагаа явуулдаг.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт: 2013 онд банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийг бүс нутгаас хамааран өсгөсөн бөгөөд дүүргийн хэмжээнд хувь нийлүүлсэн хөрөнгийг 100 сая рупигээс 300 сая рупи, бүс нутгийн хэмжээнд 150 сая рупигээс 400 сая рупи, хөдөө орон нутгийн хэмжээнд 250 сая рупигээс 500 сая рупи, улсын хэмжээнд 500 сая рупигээс 1 тэрбум рупи болгон өсгөжээ.

Зохих түвшний бодлого боловсруулагчид хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлэх болсон шалтгааныг “Хувь нийлүүлсэн хөрөнгө өндөр байх нь хөрөнгө оруулагчид болон эздийн үүргийг нэмэгдүүлж, өөрсдийгөө хамгаалах идэвхжүүлэлтийг бий болгодог ба мөн үүгээрээ зохих хяналт болон удирдлагыг урамшуулдаг” хэмээн тайлбарлажээ.

6. БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛС



Бичил санхүүгийн зах зээл: Вьетнам улсын санхүүгийн зах зээлд нийт 1225 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба эдгээрийн 17 нь санхүүгийн компани, 52 нь бичил санхүүгийн байгууллага, 12 нь санхүүгийн түрээсийн компани, 1144 нь зээлийн сан буюу хадгаламж зээлийн хоршооны хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд байна. Арилжааны банкуудын зээлийн жилийн дундаж хүү 10.5 хувь байдаг бол зээлийн сангийн жилийн хүү 10 хувьтай байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт: Санхүүгийн салбарыг Вьетнам улсын төв банк зохицуулдаг ба 2006 онд анх удаа хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоожээ. Банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 50 тэрбум вьетнам дон буюу 2.2 сая ам.доллар байсныг 2011 оны 1 дүгээр сард харгалзан 500 тэрбум дон буюу 22.1 сая ам доллар болгон өсгөжээ. Бичил санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөсөн нь 2008 онд зээлийн сангууд дампуурч, олон тооны орлого

багатай иргэдийн хадгаламж буцаан төлөгдөөгүйтэй холбоотой. Үүний улмаас Вьетнам улсын банк хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахаар банк болон бичил санхүүгийн байгууллагуудын 2006 онд тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгө болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг өсгөсөн байна. Ингэхдээ жижиг санхүүгийн байгууллагуудад үр ашигтай үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлж, боломж олгох үүднээс хувь нийлүүлсэн хөрөнгийг 4 жилийн хугацаанд үе шаттайгаар нэмэгдүүлжээ.

ДҮГНЭЛТ

Улс орнуудын хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөсөн туршлагаас үзэхэд бичил санхүүгийн зах зээлийг бэхжүүлэх, чадавхжуулах, ирээдүйд үүсэж болох болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зах зээл дэх мэргэжлийн оролцогчдыг нэмэгдүүлэх, компанийн засаглалыг сайжруулах, үр ашгийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэдэг байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өсгөсөн байдал нь улс орнуудын хувьд харилцан адилгүй бөгөөд 1.5–аас 12.6 сая ам.долларын интервалд багтаж байна. Камбож улс банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийг хамгийн их буюу 24 дахин өсгөж, 1.5 сая ам.долларт хүргэсэн бол Пакистан, Бангладеш, Гана зэрэг улсууд 2 дахин өсгөж харгалзан 9.2 сая, 12.6 сая, 3.5 сая ам.доллар болгожээ. Түүнчлэн Камбож, Энэтхэг, Вьетнам зэрэг улс орнуудад жижиг банк бус санхүүгийн байгууллагуудаа дэмжиж, боломж олгох үүднээс тодорхой хугацаанд үе шаттайгаар хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөх бодлого баримталсан байна.

Монгол улсын бичил санхүүгийн институцийн ам.доллаароор илэрхийлсэн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бусад улс орнуудынхтай харьцуулахад бага түвшинд байна.

	Камбож	Пакистан	Бангладеш	Гана	Вьетнам	Энэтхэг
Хүн ам	15.6 сая	189 сая	161 сая	27.4 сая	91.7 сая	1.3 тэрбум
Нэг хүнд ногдох ДНБ	\$1158	\$1435	\$1211	\$1369	\$2111	\$1598
Нийт ББСБ тоо	54	7 (289)	32	66	1225	36347
Дүрмийн сан өсгөсөн огноо	2016–2018 он	2011–2013 он	2011–2012 он	2013 он	2011–2014 он	2014–2017 он
Өмнөх дүрмийн сан	\$62.5 мянга	500 сая рупи	500 сая така	7 сая седи	50 тэрбум дон	2.5 сая рупи
Нэмэгдсэн дүрмийн сан	\$1.5 сая	1 тэрбум рупи	1 тэрбум така	15 сая седи	500 тэрбум дон	20 сая рупи
Өсөлт	24 дахин их	2 дахин их	2 дахин их	2 дахин их	10 дахин их	8 дахин их
ХНХ–ийг нэмэх болсон шалтгаан	Санхүүгийн салбарыг бэхжүүлэх, ирээдүйд үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Компанийн засаглалыг сайжруулах	Санхүүгийн зах зээлийн эрсдэл даах чадавхыг бэхжүүлсэн	ББСБ–уудын тоо огцом өсөж, зах зээлд эрсдэл өндөртэй тоглогчдын тоо нэмэгдсэн	Харилцагчдын эрх ашгийг хамгаалах, зохистой харьцааг сайжруулах	Зээлийн хэт тэлэлт, хүүгийн түвшин өндөр, ББСБ–уудын төлбөрийн чадвар муудсан



БАЙР СУУРЬ

2016 онд Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын хувь нийлүүлсэн хөрөнгийг үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлогын шийдвэр гаргасан. Уг шийдвэрийн хэрэгжилтийн байдал, үр дүнгийн талаар тус Хорооны Судалгаа, эрсдэлийн шинжилгээний хэлтсийн дарга Н.Хүдэрчулуунтай ярилцлаа.

–Сүүлийн үед ББСБ-уудын талаарх сэдэв олон нийтийн сонирхлыг ихээхэн татах болсон байна. Энэ салбарын өнөөгийн байдал, зах зээлд эзлэх хувь хэмжээ ямар байгаа тухай яриагаар ярилцлагаа эхэлье.

–Санхүүгийн зах зээл дээр нийт 540 банк бус санхүүгийн байгууллага Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Банк бус санхүүгийн байгууллагууд нь хуулийн дагуу нийт 10 төрлийн үйл ажиллагааг эрхлэх боломжтой ба нийт байгууллагуудын 90 гаруй хувь нь зээлийн үйлчилгээг дагнан болон бусад үйлчилгээтэй хавсран эрхэлж байна. Банкны салбартай харьцуулахад ББСБ-уудын эдийн засагт эзлэх хувь хэмжээ бага байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд салбарын хэмжээ болон зах зээлд нийлүүлж буй зээлийн бүтээгдэхүүний хэмжээ тасралтгүй өсөж байна. Тухайлбал, 2018 оны гуравдугаар улирлын байдлаар ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 32.7 хувиар өсөж 1.2 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэ нь өөрөө ДНБ-ий 4.2 хувь, банкны салбарын нийт хөрөнгийн 3.9 хувьтай тэнцэж байгаа юм. Харин салбарын нийт зээлийн үлдэгдэл 37 хувиар өсөж, 811.6 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбартай харьцуулахад 4.8 хувь байна. ББСБ-уудын олгож буй зээлийн хэмжээ нь банкны салбартай харьцуулахад маш бага байгаа ч

банкны үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй иргэдэд бага дүнтэй зээлийг богино хугацаатайгаар олгодгоороо онцлогтой. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 70 гаруй хувийг нэг жилээс бага хугацаатай олгосон зээл, 84 хувийг иргэдэд олгосон зээл бүрдүүлж байна.

–СЗХ-ноос ББСБ-уудын дүрмийн санг нэмэгдүүлэхээр шийдвэрлээд хоёр жил гаруйн хугацаа өнгөрч байна. Энэ шийдвэрийг гаргах шаардлага, үндэслэл юу байсан бэ?

–СЗХ олон талын судалгаа болон баримтан дээр үндэслэн энэ шийдвэрийг гаргасан. Тухайн үед эдийн засгийн өсөлт удааширсан, түүнийгээ дагаад арилжааны банкуудын зээлийн нийлүүлэлт хумигдсан шинжтэй байсан. 2011–2013 онуудад 50 орчим хувийн өсөлттэй байсан банкны салбарын зээлийн нийлүүлэлт 2015 оны хоёрдугаар улирлаас эхлэн буурч эхэлсэн. Тухайлбал, банкны салбарын нийт зээлийн хэмжээ 2015 онд дунджаар –1.8 хувь, 2016 онд 1.9 хувийн өсөлттэй байсан. Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн энэ нөхцөл байдлаас шалтгаалан иргэд, аж ахуй нэгжийн зээлийн эрэлт өсөж эхэлсэн. Үүнийг дагаад зээлийн хүү өссөн, улмаар салбарын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдсэн зэрэг сөрөг үр дагаврууд зах зээлд бий болоод байсан. Мөн тухайн үед банк бус санхүүгийн үйл

ажиллагаа эрхлэх сонирхолтой этгээдүүдийн тоо хурдацтай нэмэгдэж байсан. 2014–2016 оны хооронд ББСБ-уудын тоо хоёр дахин огцом нэмэгдсэн. Ингэснээр зээлийн зах зээлийн тэлэлт тодорхой хэмжээнд явагдсан боловч салбарт өргөжилтийн үр өгөөж төдийлөн бий болоогүй. Түүнчлэн санхүүгийн зах зээлд оролцогчдын үйл ажиллагаа өөрөө хэрэглэгчдийн итгэл дээр суурилан явагддаг учраас салбарын мэргэжлийн оролцогчид болох ББСБ-ууд нь хариуцлага даах чадвартай, үйл ажиллагаа нь тогтвортой, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байх зайлшгүй шаардлагатай байдаг.

Мөн сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлд технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд хурдацтай нэвтэрч, уламжлалт зах зээлийг нэлээд эвдэж байна. Энэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээнүүд нь санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээ үзүүлэх хугацааг бууруулах зэрэг олон давуу тал, үр ашгийг бий болгож байна. Одоогийн байдлаар СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд хоёр ч ББСБ технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж байгаа бөгөөд салбарын нийт зээлдэгчдийн 40 гаруй хувь нь гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг



ашиглаж байна. Цаашид ч санхүүгийн зах зээлд финтекийн үйлчилгээнүүд улам хурдтай нэвтрэх, зах зээл өөрөө технологид суурилан ажиллах хандлагатай байна. Ер нь энэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээнүүд нь ББСБ-уудын харилцагчид бага зардлаар, үр ашигтайгаар бүтээгдэхүүн хүргэх, цаашлаад арилжааны банкуудтай өрсөлдөхүйц хэмжээнд үйл ажиллагаагаа өргөжүүлэх зэрэг том боломжуудыг олгож байна. Мэдээж эдгээр технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэхэд нөгөө л хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь том хөшүүрэг болж байдаг.

–Хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх нь ББСБ-даа ямар ач холбогдолтой байдаг вэ? Үүнийг хэрхэн тооцоолсон бэ?

–Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх нь зөвхөн байгууллагын үйл ажиллагааг тэлэхээс гадна үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник хэрэгсэл, програм хангамжийг сайжруулах, мөн шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх зэрэг давуу талыг олгох ба байгууллагын хүний нөөц, засаглал, комплаенс, эрсдэлийн удирдлага, менежментийн үйл ажиллагаа зэрэг олон зүйлд эерэгээр нөлөөлдөг. Жишээлбэл, Санхүүгийн зохицуулах хороо Монгол улсад ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн дагуу зохицуулалтын байгууллагуудын мөнгө угаах эрсдэлийн түвшинг үнэлсэн бөгөөд банк бус санхүүгийн байгууллагуудын мөнгө угаах эрсдэлийн түвшин бага байсан хэдий ч эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж буй арга хэмжээ хангалтгүй түвшинд байсан нь үнэлгээний үр дүнд сөргөөр нөлөөлж байсан. Уг үнэлгээ нь байгууллагуудын засаглал, сургалт, хүний нөөц, комплаенсын хэрэгжилт, эрсдэлийн үнэлгээ, удирдлага, хяналтын тогтолцоо, менежментийн үйл ажиллагаа зэрэг олон хүчин зүйлүүдийг багтаасан ба хөрөнгийн хэмжээ ихтэй, том байгууллагуудын хувьд үнэлгээний үр дүн харьцангуй сайн байсан.

–Гадны орнуудын туршлага ч юм уу, жишээ,

алдаа, оноог нь судалж үзсэн үү?

–Судлалгүй яахав. Сая дурдсан салбарын нөхцөл байдал, чиг хандлагаас гадна ББСБ-ууд хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэх чадамжтай эсэх, мөн олон улсад энэ төрлийн бодлогыг ямар үндэслэлтэйгээр гаргадаг талаарх судалгаануудыг хийсэн. Ингэхдээ хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх нь зээлийн түвшинд хэрхэн нөлөөлдөг талаарх төсөөллийг эконометрикийн дөрвөн аргачлалыг ашиглан гурван хувилбараар тооцож гаргасан. Эдгээр төсөөллийн үр дүнгээс харахад уг бодлогын шийдвэр бүрэн хэрэгжиж дууссаны дараагаар салбарын нийт хөрөнгө дунджаар 2.6 их наяд төгрөгт, зээлийн бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгдэн 1.7 их наяд төгрөгт хүрэх ба зээлийн хүүгийн түвшин 2018 он гэхэд 3.4 хувь, 2019 он гэхэд 2.6 хувь, 2020 он гэхэд 2.1 хувь хүртлээ буурах бүрэн боломжтой гэсэн үр дүн гарсан. Тиймээс эдгээр судалгаа, нөхцөл байдалд үндэслэн чадавхтай, хариуцлагатай мэргэжлийн оролцогчдоор салбарыг бүрдүүлэх, иргэдэд хямд үнээр санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хялбар хүргэх, иргэд, аж ахуй нэгжүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зэрэг үндэслэлүүдээр Хороо ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх шийдвэрийг гаргаж байсан.


–Та нарын хийсэн олон улсын судалгаанаас өөр онцлох дүр зургууд ажиглагдсан уу? Жишээ нь, санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх шалтгаан нь голчлон юу байдаг, эсвэл манай ББСБ-уудтай ижил байгууллагуудын хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлага хэр хэмжээнд байдаг гэх зэргээр?

–Улс орнуудын хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөсөн туршлагаас үзэхэд бичил санхүүгийн зах зээлийг бэхжүүлэх, чадавхжуулах, ирээдүйд үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зах зээл дэх мэргэжлийн оролцогчдыг нэмэгдүүлэх,

компанийн засаглалыг сайжруулах, үр ашигт байдлыг өсгөх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэдэг болох нь харагдсан. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өсгөсөн байдал нь улс орнуудын хувьд харилцан адилгүй бөгөөд манай улстай ижил хөгжиж буй санхүүгийн зах зээлтэй улсуудад 1.5 саяас 12.6 сая ам.долларын интервалд багтаж байна. Камбож улс ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийг хамгийн их буюу 24 дахин өсгөж, 1.5 сая ам.долларт хүргэсэн бол Пакистан, Бангладеш, Гана зэрэг улсууд 2 дахин өсгөж харгалзан 9.2 сая, 12.6 сая, 3.5 сая ам.доллар болгож байсан. Түүнчлэн Камбож, Энэтхэг, Вьетнам зэрэг улс орнуудад жижиг ББСБ-уудаа дэмжиж, боломж олгох үүднээс тодорхой хугацаанд үе шаттайгаар хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөх бодлого баримталж байна. Манай улсын бичил санхүүгийн байгууллагуудын ам.доллараар илэрхийлсэн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бусад улс орнуудынхтай харьцуулахад бага түвшинд байна.

–Түрүүн та судалгааны дүнд хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлснээр зээлийн хүүг бууруулах бүрэн боломжтой гэсэн дүн гарсан гэлээ. Тэгвэл уг шийдвэрийг хэрэгжүүлснээр зах зээлд ямар зэрэг өөрчлөлтүүд гараад байна вэ?

–Аливаа бодлого, шийдвэрийг гаргахдаа судалгаа, шинжилгээнд суурилдаг боловч, үр нөлөөг нь тухай бүр үнэлэхэд хэцүү байдаг. Гэхдээ статистик мэдээллээс харахад зах зээлд хэд хэдэн эерэг өөрчлөлтүүд ажиглагдаж эхлээд байна. Тухайлбал, хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх шийдвэр хэрэгжиж эхлэхээс өмнө буюу 2016 оны гуравдугаар улиралд салбарын нийт хөрөнгө 724.2 тэрбум төгрөг байсан бол 2018 оны гуравдугаар улиралд 1.2 их наяд төгрөгт хүрч 66 хувиар өссөн. Харин нийт зээлийн хэмжээ 81.3 хувиар нэмэгдэж 811.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Активын бүтцээс харвал нийт хөрөнгийн өсөлтийн 76.2 хувийг нийт зээлийн өсөлт бүрдүүлж



байна. Өөрөөр хэлбэл салбарын эх үүсвэрийн хэмжээ нэмэгдсэнээр зээлийн нийлүүлэлт нэмэгдэж байна гэсэн үг. Харин сарын жигнэсэн дундаж хүүгийн түвшин шийдвэр хэрэгжиж эхлэхээс өмнө 4.2 хувь байсан бол 2018 оны гуравдугаар улирлын байдлаар 3.3 хувь буюу 0.9 пунктээр буурсан дүнтэй байна. Зээлийн хүүгийн бууралтад эдийн засгийн таатай нөхцөл байдал нөлөөлсөн байж болох ч зээлийн бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгдсэн нь үнийн түвшинг бууруулах гол нөлөөг үзүүлсэн гэж харж байна. Мөн зээлийн хүүг бууруулах зорилгоор Хорооноос энэхүү шийдвэрийг гаргасны дараагаар Голомт банкнаас “Зээлийн хүүг бууруулах үндэсний стратеги”, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)–өөс “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018–2023” зэрэг бодлогын баримт бичгийг боловсруулан баталсан нь СЗХ–ны бодлогын санаачилга санхүүгийн зах зээлд оролцогчдод бага ч болов дохио үзүүлсэн болов уу гэж бодож байна. Мөн зөвхөн зээлийн хүүгийн бууралт зэргээс гадна салбарт ажиллагсдын тоо 30.8 хувиар өсч, ББСБ–ууд нь нийт 2600 гаруй ажлын байрыг бий болгосон зэрэг бусад эерэг үзүүлэлт ч гарсан байна.

–Зээлийн нийлүүлэлт нэмэгдсэн гэхээр нэг талаас иргэд, байгууллагууд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хүртээд, зах зээлийн оролцоо нь нэмэгдээд ирж байна гэж харж болох байх. Эргээд үүнд сөрөг тал нь юу байж болох вэ?

–ББСБ–уудын зээлдэгчдийн тоо 2016 оны гуравдугаар улиралд 64 мянга байсан бол 2018 оны гуравдугаар улиралд 3.4 дахин нэмэгдэж 217 мянгад хүрсэн байна. Зээлдэгчдийн тооны энэ өсөлт нь таны хэлснээр нэг талаасаа санхүүгийн үйлчилгээний хүртээмж өсөж байгааг илэрхийлэх боловч иргэдийн өрийн дарамт нэмэгдэх аюул бас байдаг. Тиймээс бид нэг зээлдэгчид ногдох зээлийн хэмжээг зайлшгүй харах шаардлагатай. 2016 оны гуравдугаар улиралд ББСБ–ын нэг зээлдэгч

дунджаар 7.0 сая төгрөгийн зээлтэй байсан бол энэ улиралд уг үзүүлэлт 3.7 сая төгрөг буюу бараг 2 дахин буурсан байна.

–2016 онд чанаргүй зээлийн хэмжээ өссөн байсан гэсэн. Тэгвэл СЗХ–ны шийдвэрийн дараа ямар өөрчлөлт гарсан бэ?

–Ер нь сүүлийн хоёр жилийн хугацаанд банк бус санхүүгийн салбарын чанаргүй зээлийн хувь буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал 14.3 хувь хүртэл өсөөд байсан чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2018 оны гуравдугаар улирлын байдлаар 10.6 хувь хүртэл буурсан дүнтэй байна.


–Банк бус санхүүгийн зах зээлд аль хэдийн эерэг өөрчлөлтүүд ажиглагдаад эхэлсэн байгаа нь харагдаж байна. Үе шаттайгаар хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх энэ шийдвэрийн хэрэгжилт өнөөдөр ямар үзүүлэлттэй байна вэ?

–Өмнө дурдсанчлан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр нь үе шаттайгаар хэрэгжинэ. Бас бүсийн ялгавартай. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ–ууд хувь нийлүүлсэн хөрөнгөө 2018 онд 1 тэрбум, 2019 онд 1.4 тэрбум, 2020 онд 1.9 тэрбум, 2021 он гэхэд 2.5 тэрбум хүртэл нэмэгдүүлэхээр заасан байгаа. Сүүлийн хоёр жилийн хугацаанд давхардсан тоогоор нийт 429 ББСБ хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ 332.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 2018 оны гуравдугаар улирлын байдлаар шийдвэрийн хэрэгжилт 95 хувьтай байна. Ер нь ББСБ–ууд хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх шийдвэрийг зардал бус хөрөнгө оруулалт гэж үзэх нь зөв юм. Хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсний дүнд байгууллагуудын чадавх сайжрахаас гадна ашигт ажиллагааны үзүүлэлтүүд мөн өссөн дүнтэй байна. Зээлийн хүүгийн түвшин буурсаны зэрэгцээ байгууллагуудын үр ашигт байдал сайжирч ашгийн түвшин нэмэгдсэн нь ББСБ–уудын зах зээлд зээлийн бүтээгдэхүүний эрэлт өндөр байгааг харуулж байна.

–Цаашид СЗХ санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зээлийн хүүг бууруулах чиглэлээр ямар бодлого баримтлан ажиллах вэ?

–СЗХ өнгөрсөн есдүгээр сард дунд хугацааны буюу 2018–2021 оны стратеги төлөвлөгөөгөө батлан хэрэгжүүлээд явж байна. Энэхүү стратеги төлөвлөгөөнд нийт зургаан зорилтыг тусгасны стратегийн зорилт 3–д, “Санхүүгийн бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хямд, хялбар, түргэн шуурхай, чирэгдэлгүй хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх” гэж тусгасан байгаа. Бид энэ зорилтынхоо хүрээнд санхүүгийн хүртээмжийг сайжруулах бодлогын баримт бичиг боловсруулж хэрэгжүүлэх, зах зээлд оролцогчдын чадавхыг нэмэгдүүлэх, хямд эх үүсвэртэй, урт хугацаат зээл болон бусад санхүүгийн хэрэгслийг зах зээлд гаргахыг бодлогоор дэмжих, технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх эрх зүйн болон эрсдэлийг хянах тогтолцоог бүрдүүлэх гэсэн дэд зорилтуудыг тавьж, үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөгөө гаргаад хэрэгжүүлж байна. Мөн Засгийн газраас баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан “Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”, “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018–2023” зэрэг бодлогын баримт бичгүүдэд салбарын оролцогчдыг чадавхжуулж, олон тулгуурт санхүүгийн зах зээлийг бий болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэд, олон нийтэд хямд үнэтэй өргөн сонголт бүхий санхүүжилтийн арга хэрэгслийг санал болгоход чиглэгдсэн олон ажил тусгагдсаныг хэрэгжүүлж байна. Эдгээр бодлогын баримт бичгүүдийг 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 90–100 хувийн биелэлттэй байна.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

**“ҮНЭТ ЦААС БАРЬЦААЛАХ ТУХАЙ ЖУРАМ”**

“Үнэт цаас барьцаалах тухай журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан.

ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Хууль зүйн үндэслэл: Улсын Их Хурлаас 2015 оны 7 дугаар сарын 02-ны өдөр баталсан Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт “Зохицуулалттай зах зээл дэх үнэт цаасыг барьцаалахтай холбогдсон харилцааг энэ хуульд үндэслэн үнэт цаасыг зохицуулах, хянах эрх бүхий байгууллагын тогтоосон журмаар зохицуулна” гэж заасан нь “Үнэт цаас барьцаалах тухай журам”-ын төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болсон.

Улсын Их Хурлын 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн хэрэгжиж эхлэх хугацааг 2017 оны 3 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хойшлуулсан бөгөөд тус хуульд үндэслэн журмын төслийг боловсруулсан.

Практик шаардлага: Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсэн бий болоод өдгөө 27 жилийн

хугацаа өнгөрч байгаа ч, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түвшнээр бусад ижил түвшний эдийн засагтай орнуудтай харьцуулахад доогуур буюу хөгжиж буй / frontier market / түвшинд байгаа нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхол буурах, улмаар үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа, хөрвөх чадвар сонгодог утгаар хөгжих боломжийг бууруулж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой урт хугацааны төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг хөрөнгийн зах зээлээр дамжуулан татах бололцоог бүрдүүлж чадахгүй байна.

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн суурь нөхцөл болох хууль, эрх зүйн орчин сайжирч, 2010 онд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, 2011 онд Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2013 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, шинээр Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, 2011 онд Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль тус тус батлагдсанаар хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн зохицуулалт тодорхой болох, мэргэжлийн хөрөнгө оруулагчид бий болох, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэх боломжийг бүрдүүлсэн. Тухайлбал, 2018 оны 3 дүгээр улирлын байдлаар хөрөнгийн зах зээлд нийт 17 хөрөнгө оруулалтын менежментийн компани, 12 хувийн хөрөнгө оруулалтын сан, 3 кастодиан

банк, 54 үнэт цаасны компани тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль батлагдсантай холбоотойгоор иргэн, хуулийн этгээд өөрийн эзэмшлийн үнэт цаасыг барьцаанд тавих боломж бүрдсэн.

Журмын зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Журам нь 5 бүлэгтэй бөгөөд 1 дүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу журмын зорилт, журам болон холбогдох хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээг тусгасан. Журмын 2 дугаар бүлэгт үнэт цаасыг барьцаанд тавих үйл ажиллагаа, 3 дугаар бүлэгт үнэт цаас тусгаарлах, өмчлөх эрхийг шилжүүлэх, тусгаарлалтаас чөлөөлөх үйл ажиллагаа, 4 дүгээр бүлэгт Хороонд мэдээлэл хүргүүлэх, 5 дугаар бүлэгт хариуцлагын талаар тус тус тусгасан болно.

Журмын төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засагт дараах эерэг нөлөө үзүүлэх боломжтой

Зохицуулалттай зах зээлийн үнэт цаасыг урт хугацаанд тогтвортой эзэмших сонирхол бүхий хөрөнгө оруулагчид богино хугацааны санхүүжилтийн хэрэгцээгээ хангах шаардлага тулгарах тохиолдолд барьцааны зүйл болгон ашиглах замаар орлогын хэмжээгээ нэмэгдүүлэх боломжтой болох юм.

ФИНТЕК



РЭГТЕК

Мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт шинэ дэвшил, сорилт, боломжуудыг бий болгож байна. Финтек (FinTech) буюу дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, энэ төрлийн бизнес хандлага хэрэглэгчдэд чирэгдэл багатай, шуурхай, амар хялбар нөхцөлийг санал болгохын сацуу хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээр татаж байна. KPMG-ийн Олон улсын хэмжээнд улирал бүр тогтмол хийгддэг финтек дэх хөрөнгө оруулалтын тайланд финтекийн хөрөнгө оруулалтын хэмжээ 2018 оны хагас жилийн байдлаар 57.9 тэрбум ам.долларт хүрч нийт 875 хэлэлцээр хийгдсэн тухай дурджээ.



“2018 оны томоохон хэлэлцээрийн нэг болох Их Британи улсын төлбөр тооцоо, шилжүүлгийн WorldPay компанид 12.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн.”



Уламжлалт хэвшмэл ойлголтод өөрчлөлт бий болгосон финтекийг зохицуулах зохицуулалтын орчны хэрэгцээ шаардлага гарч ирснээр Рэгтек (Regtech) хэмээх технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалт хүчээ авч байгаагаас гадна түүнд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ тогтмол нэмэгдэж байна.

Финтекийн анхны бүрдэл хэсгүүд бий болж эхэлсэн цагаас л рэгтек буюу зохицуулалтын шийдлүүдийг судалж эхэлсэн юм. Бизнес, санхүүгийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж эхэлсэн тул зохицуулалт нь одоогийн зохицуулалтын үйл ажиллагаанд нийцэхээс гадна цахим хэлбэрт шилжиж, шийдэл гарцаа тодорхойлсон байх учиртай.

ХЭРЭГЛЭЭ

Санхүүгийн салбарт Рэгтекийн шийдлүүд нь мөнгө угаахтай тэмцэх, хэрэглэгчийг таних, кибер аюулгүй байдлаас хамгаалах, тайлангийн өгөгдөлд шинжилгээ хийх, эрсдэлийг удирдах, залилангаас урьдчилан сэргийлэх гэх мэт олон асуудлыг шийдэхэд чиглэгдэж байна. Хэрэглэгчдийн хувьд санхүүгийн зохицуулалтын дүрэм, журмыг ойлгож үйл ажиллагаагаа тэдгээрт нийцүүлэн явуулах, тайлан, мэдээллээ сайжруулах, стандартчилах, арилжаа, гүйлгээний мэдээллээ хянах, болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлох функцуудыг Рэгтек

санал болгож буй юм.

Рэгтекийн нэг хэлбэр болох Сэндбокс (Sandbox)-ийн орчин харьцангуй шинэ зохицуулалтын механизм билээ. Тус арга нь шинэ инновацлаг бүтээгдэхүүн үйлчилгээг оруулж ирсэн бизнесийг зах зээлд гаргах буюу тусгай зөвшөөрөл, лиценз зэргийг олгохоос өмнө туршилтын хэмжээнд хууль, журмын дагуу туршиж, тест хийлгэн бизнес моделийг сайтар боловсруулж үзсэний дараа зах зээлд гаргадаг. Тус арга нь шинээр бизнес эрхлэгчдийг зах зээлд тэсвэртэй өрсөлдөх чадвартай болгож, өрсөлдөөн дундаас шахагдах эрсдэлээс сэргийлэх мөн салбарын мэдээллийг бүрэн авах боломжийг бүрдүүлж өгдгөөрөө онцлог юм.

Тус механизмыг Австрали, Канад, Сингапур, Малайз, Орос зэрэг улсуудад хэрэглэж эхлээд байгаа ба өөрсдийн хяналт шалгалт хийдэг байгууллагууддаа шинээр тусдаа алба нэгж гаргаж Сэндбокс аргыг хэрэглэж тусгай зөвшөөрөл, лицензийг олгож байна.

Улс орнуудын санхүүгийн зохицуулагч байгууллагууд дүрэм журмын хэрэгжилт, мэдээлэл цуглуулах, салбарын тогтвортой байдал, зах зээлд оролцогчдын ил тод байдал, компанийн засаглал зэрэгт Рэгтекийн шийдлүүдийг ашиглан хяналт тавих боломжтойгоос гадна өөрсдийн гүйцэтгэл, зохицуулалтын механизмыг ч мөн технологи ашиглан хэрэгжүүлэх бололцоо бүрдээд байна.



Банк, санхүүгийн чиглэлээр хиймэл оюун ухаан, машин тооцоолол ашиглан зохицуулалт хийдэг байгууллагын нэг нь CUBE юм. Уг байгууллагын онцлог нь тухайн цаг мөчид олон улс, үндэстэн дамнансан санхүүгийн үйл ажиллагааг хянах, өөрсдийн платформ ашиглан шинэ бүтээгдэхүүний шийдлийг нэмэгдүүлэх, дүрэм, журмыг боловсронгуй болгох зэрэг ач холбогдолтой.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2018 оны 1 дүгээр улирлын байдлаар дэлхийн хэмжээнд нийт 629 Рэгтек компани үйл ажиллагаа явуулж байгаагаас дийлэнх нь буюу 75 хувь нь АНУ, Их Британи, Австрали, Швейцар, Ирланд гэсэн 5 улсад үйл ажиллагаагаа явуулж байна. 2017 онд Рэгтек компаниудад 1.1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн бол 2018 оны 1 дүгээр улиралд 533 сая ам.долларт хүрсэн



“Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотын Санхүүгийн үйлчилгээний зохицуулагч байгууллага DFSA (Dubai Financial Services Authority) нь “Fin-Tech Hive” хэмээх шинэ инновацийн компани үүсгэн байгуулагдахтай зэрэгцэн хамтын санхүүжилтийн журмыг баталж, 2017 оноос эхлэн инновацийн туршилтын тусгай зөвшөөрлийг өгч эхлээд байна”



нь тус оны сүүлээр хөрөнгө оруулалт өмнөх оноос илүү өндөр өсөлт үзүүлэх хүлээлтийг дагуулж байна. Цаашлаад олон улсад нэр хүндтэй санхүүгийн байгууллагуудад ажиллаж байсан туршлагатай рэгтек шинжээчдээс бүрдэх “Regtech analyst” хэмээх олон улсын байгууллагаас гаргасан дүгнэлтээр 2020 онд тус зах зээлийн хэмжээ 80 тэрбум ам.долларт хүрэхээр тооцоологдож байна.

Бизнесийн шинж чанарын хурдацтай өөрчлөлтөд зөв шийдвэр гаргахын тулд зохицуулагчид технологитой холбогдох дэд бүтцийн өөрчлөлтүүдийг хийж, ялангуяа санхүүгийн үйлчилгээний салбарт, дижитал өөрчлөлтийг хийхэд бэлтгэн дэд бүтэц, зохицуулалтын орчин, үйл ажиллагаанд шинэчлэлт хийх шаардлага үүсээд байна. Энэхүү хэрэгцээ шаардлага үүссэнтэй холбоотойгоор 2017 онд АНУ 115 дахь Конгрессийн үеэр АНУ-ын анхны Рэгтекийн хууль болон Санхүүгийн ил тод байдлын тухай хуулийг танилцуулсан байна. Энэхүү хууль нь АНУ-ын санхүүгийн зохицуулагч байгууллагуудын мэдээллийн сангийн хэлбэр, бүтцийг өмнө нь цуглуулсан мэдээлэлд тохируулан өөрчлөхөд чиглэж байгаа юм.

СОРИЛТУУД

Технологийн боломж, чадамжаас хамаарч зах зээлд байхгүй цоо шинэ, инновацлаг бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагаа бий болох нь Рэгтек зохицуулалтын хэрэгцээ, шаардлагыг нэмэгдүүлж, хөгжүүлэлт хийх хөрөнгө оруулалтыг тасралтгүй өсгөсөөр байна.

Гэвч Рэгтек зохицуулалтын орчинг боловсронгуй болгоход тодорхой сорилт, бэрхшээлүүд тулгарсаар байгаа ба дараах сорилтууд нь банк, санхүүгийн салбарт түлхүү тулгардаг хэдий ч бусад салбаруудад хамааралтай гэдгийг онцлох нь зүйтэй.

- **Хууль тогтоомжийн хэрэгжилт ба хяналт шалгалт:** Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтрэхэд хууль эрх зүйн орчин дутмаг, уялдаагүй байдаг нь дүрэм журмын хэрэгжилтийг хангах үйл явцыг төвөгтэй болгодог.
- **Зохицуулагч байгууллагуудын уялдаа холбоо болон тодорхой бус байдал:** Зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж буй байгууллага үйл ажиллагаа явуулахад төрийн байгууллагуудын уялдаа холбоо сул байдаг шалтгаанаар гацаанд оруулах, төлөвлөгөөт ажлуудыг удаашруулах зэрэг эрсдэлүүдтэй тулгардаг.
- **Мэдээллийн аюулгүй байдал:** Технологийн салбарт мэдээллийн нууцлал, хамгаалалт маш чухал байдаг тул хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах эрх зүйн орчин болон технологийн шийдэл нь нэг том сорилт болдог. Ялангуяа технологи ашиглаж байгаа тохиолдолд төрийн байгууллагын нууц мэдээллийг хэрхэн хамгаалах талаар олон улс бүр өөр өөрсдийн онцлогоор шийдвэрлэж байна.
- **Технологийн өөрчлөлт:** Технологи шинэчлэлтийн хурд нэмэгдэж байгаа учраас бидний хэрэглэж буй технологи байнга хуучирсаар байна. Технологийн өөрчлөлтийг дагаад түүнд зарцуулж буй зардал өсөж хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх хандлагатай байгаа тул тэдгээр зардлыг бууруулах шийдлийг эрэлхийлсээр байна.
- **Дүрэм журмыг боловсруулж, дагаж мөрдөх зардал:** Нэг талаараа технологийн хөгжлийн зардалд анхаарах шаардлагатай бол нөгөө талаараа хууль эрх зүйн шинэчлэлт хийхэд, түүнийг дагаж мөрдөхөд шаардагдах зохицуулалтын зардал, хяналт шалгалтын зардлууд нэмэгдсээр байна.

ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

Регтекийн зах зээлийн хэмжээ 2018 оны байдлаар 4.3 тэрбум ам.доллар байгаа бол 2023 он гэхэд 12.3 тэрбум ам.доллар болж өсөх хандлагатай байна. Энэхүү зах зээлийг хөгжүүлэх гол хүчин зүйлүүд нь комплаенсын зардлын өсөлт, зохицуулалтын Сэндбокс хандлагын нэвтрүүлэлт, програм хангамжийн зах зээлд нэвтрэх бэрхшээл бага байх явдал зэрэг юм .

Хойд Америкийн санхүүгийн зах зээл нь хиймэл оюун ухаан, блокчейн, их хэмжээний дата сан, үүлэн тооцоолол зэрэг дэвшилтэт технологиудаар дамжуулан үйл ажиллагааны зардлаа бууруулж байгаа нь 2023 он гэхэд дэлхийн улс орнуудаас Регтекийн зах зээлээрээ хамгийн их хөгжих төлөвтэй байгаа юм.



ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ БА САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ, ИТГЭЛИЙГ ТАНДАХ СУДАЛГАА

(2018 оны 4-р улирлын байдлаар)

Иргэдийн санхүүгийн зах зээлийн оролцоо болон санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийг судлах зорилготой энэхүү судалгаа нь 2016 оны гуравдугаар улирлаас эхлэн хийгдэж байна. Судалгааг санамсаргүй түүврийн аргаар хийдэг бөгөөд 2018 оны дөрөвдүгээр улирлын хувьд Монгол Улсын хэмжээнд 1000 орчим иргэдийг хамруулсан.

Судалгаанд нийт 989 санамсаргүй сонгогдсон иргэд хамрагдсан бөгөөд судалгаа нь Улаанбаатар хот болон 21 аймгийг хамарсан. Оролцогчдыг нас, боловсрол, амьжиргааны түвшин болон хот хөдөө амьдардаг гэсэн хүчин зүйлээр нь бүлэглэн шинжилгээг хийсэн. Нийт судалгаанд хамрагдагсдын 43.3% нь эрэгтэй, дундаж нас нь 39.7, 49.4% нь Улаанбаатарт оршин суудаг байна.

Боловсролын хувьд доогуур болон дээгүүр боловсролтой гэж ангилсан. Доогуур гэдэгт дунд болон түүнээс доогуур боловсролтой иргэд, дээгүүр гэдэгт дээд болон техник мэргэжлийн ба түүнээс дээш боловсролтой иргэд орно. Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 56.2 хувь нь дээгүүр боловсролтой, 43.8 хувь нь доогуур боловсролтой байна.

Иргэдийн амьжиргааг сууцны төрөл болон өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого


гэсэн хувьсагчдаар тодорхойлж авч үзсэн. Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 51.9 хувь нь гэр болон хашаа байшинд амьдардаг бол 48.1 хувь нь орон сууцанд амьдардаг байна. Сууцны төрлөөс гадна өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого үзүүлэлтээр судалгаанд хамрагдсан иргэдийг орлого бага болон орлого өндөр гэсэн 2 бүлэг болгон ангилсан. Эхний бүлэг буюу орлого бага гэдэгт өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого нь 200 хүртэлх төгрөгтэй тэнцэх өрхийн иргэдийг, хоёр дахь буюу орлого өндөр гэдэгт өрхийн гишүүнд ногдох сарын орлого нь 200 мянга ба түүнээс дээш төгрөгтэй тэнцэх өрхийн иргэдийг оруулсан. Судалгаанд хамрагдсан иргэдийн 40.2 хувь нь энэхүү ангиллын дагуу орлого бага, харин 59.8 хувь нь орлого өндөр гэсэн ангилалд багтаж байна.

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОО

Зээлийн зах зээл: Иргэдээс өнгөрсөн 6 сарын хугацаанд санхүүгийн байгууллагуудаас зээл авсан эсэхийг асуусан. Өмнөх улирлын судалгаанд оролцсон иргэдийн 45.3% зээл авч байсан бол 2018 оны 4-р улирлын байдлаар, иргэдийн 40.8 хувь нь зээл авчээ. Нийт иргэдийн 26.0 хувь нь арилжааны банкнаас, 9.8 хувь нь ломбардаас, 6.3 ББСБ, 10.8 хувь нь хувь хүнээс зээл авчээ.

Зээл авсан иргэдийг зээл олгосон байгууллагаар нь харвал арилжааны банк 63.6%, ломбард 24.0%, хувь хүн 26.5%, ББСБ 15.3% зээлж байна. Иргэдийн 50.5% албан бус сектор буюу ломбард, хувь хүнээс зээл авчээ.

Зураг 1. Иргэдийн зээл авсан байдал



Тухайн санхүүгийн байгууллагыг сонгон үйлчлүүлсэн шалтгааныг судалгаанд оролцогсдоос асуусан. Үйлчилгээний түргэн шуурхай байдал хэрэглэгчийн хувьд хамгийн чухал шалтгаануудын нэг болдог байна. Арилжааны банкны хувьд зээлийн хүү хамгийн чухал үзүүлэлт бөгөөд зээлийн үргэлжлэх хугацаа ч бас чухал байна. Харин ББСБ-ын хувьд барьцаа хөрөнгө, баталгаанд тавигдах шаардлага болон танил тал дараагийн гол шалтгаан болдог. Ломбардаар үйлчлүүлэхэд хамгийн чухал шалгуур нь


үйлчилгээний түргэн шуурхай байдал болон барьцаа хөрөнгө, баталгаанд тавигдах шаардлага байна.

Даатгалын зах зээл: 2018 оны 4 улирлын байдлаар нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 64.2 хувь нь ямар нэг сайн дурын даатгалд хамрагдаагүй гэжээ. Энэ нь өмнөх улиралтай харьцуулахад 11.4 пунктээр бага байна. Харин 23.8 хувь нь сайн дурын ямар нэг даатгалтай бөгөөд энэ нь өмнөх улиралтай харьцуулахад бага зэрэг (2 пункт)

өссөн, 2016 оны 3 улиралтай харьцуулахад 14 пунктээр өндөр байна.

Сайн дурын даатгалд хамрагдалт нь иргэдийн хүйс, боловсрол, сууцны нөхцөл болон орлогоос хамааран ялгаатай байна. Тухайлбал, эрэгтэй, бакалавр болон түүнээс дээш боловсролтой, орон сууцанд амьдардаг болон орлого өндөр бүлгийн иргэдийн даатгалд хамрагдалт эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад өндөр байна.

Зураг 2. Ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаг эсэх, бүлгээр



Сайн дурын даатгалд хамрагдалтыг бүлгээр харахад боловсрол болон орлого буюу амьжиргааны түвшний бүлгийн хувьсагчдаар хамгийн их ялгаа байна. Өндөр боловсролтой иргэдийн 30.3 хувь нь даатгалд хамрагдсан байгаа нь эсрэг бүлгээсээ 13.2 пунктээр илүү байна. Харин орон сууцанд амьдардаг иргэдийн 31.6 хувь нь даатгалтай байгаа нь гэр хороололд амьдардаг иргэдтэй харьцуулахад 14.8 пунктээр өндөр байна. Мөн түүнчлэн өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого нь хоёр зуун мянгаас дээш иргэдийн хувьд даатгалд хамрагдалт 26.8 хувьтай байхад бага орлоготой иргэдийн 18.8 хувь нь сайн дурын даатгалд хамрагджээ.

Даатгалын хэрэгцээ шаардлагын хувьд даатгалын төрлөөс хамааран иргэдийн таашаал өөр өөр байна. Тухайлбал, эрүүл мэндийн даатгалыг иргэдийн 41 хувь нь хамгийн хэрэгцээтэй гэж үзэж байна. Үүний дараа гэнэтийн осол, эмчилгээний даатгал (15.3%) –ыг нэрлэжээ. Иргэдийн 6.5 хувь нь энэ асуултад сайн мэдэхгүй гэж хариулсан.

Даатгалд хамрагдаагүй иргэдээс хамрагдаагүй шалтгааныг тодруулахад 34.3 хувь нь хэрэгцээ шаардлагагүй, 16.4 хувь нь даатгалын хураамж, төлбөр өндөр, 9.8

хувь нь даатгалд итгэдэггүй, 25.7 хувь нь даатгалын талаар мэдэхгүй гэсэн хариулт өгчээ.

Хөрөнгийн зах зээл: Хөрөнгийн зах зээл бол санхүүгийн зах зээлийн нэг чухал салбар юм. Иймд энэхүү судалгааны хүрээнд хөрөнгийн зах зээлийн оролцооны талаар иргэдээс хэд хэдэн асуултаар мэдээлэл авсан.

Иргэдийн 17.3% нь хөрөнгийн биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож

байсан гэж хариулсан бол 74.5% нь үгүй, 8.2% нь мэдэхгүй гэж хариулсан. Энэ үзүүлэлт өмнөх улиралд судалгаанд оролцогсдын арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсан гэсэн хариулттай ойролцоо байна. Мөн 2018 оны 3 улирлын судалгаагаар энэхүү асуултад 30.1 хувь нь мэдэхгүй гэж хариулж байсан бол 2018 оны 4 улиралд энэ хариулт 22 орчим пунктээр буурчээ.

Зураг 3. Хөрөнгийн биржийн арилжаанд оролцох сонирхол



Хөрөнгийн биржийн арилжааг сонирхохгүй байгаа шалтгааныг асуухад 34.2 хувь нь арилжаанд хэрхэн оролцохоо мэдэхгүй, 64.0 хувь нь мэдээлэл байхгүй гэж хариулсан.

Түүнчлэн, 14.2 хувь нь арилжаанд оролцох хөрөнгө, мөнгө байхгүй шалтгаанаар сонирхдоггүй байна.

САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ИТГЭХ ИТГЭЛ БОЛОН МЭДЛЭГ


Судалгаанд хамрагдсан иргэдээс санхүүгийн зохицуулагч байгууллагууд болон зуучлагч байгууллагуудад итгэх итгэлийг 2016 оны

3, 2017 оны 1 болон 2, 2018 оны бүх дөрвөн улирлуудад тандан асуусан. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, даатгалын компаниуд, арилжааны банк, ББСБ болон ХЗХ-д итгэх итгэлийг тандсан дүнг Зураг 4-т харууллаа.

орлоготой иргэдийн итгэх итгэл 34 хувь, бага орлоготой иргэдийн итгэх итгэл 24.8 хувь байна.

Энэ удаагийн судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд СЗХ болон хөрөнгийн бирж гэсэн хоёр байгууллагын хувьд итгэх итгэл нь иргэдийн хаана амьдардгаас хамааран ялгаатай байна. Тухайлбал, хотын иргэдийн хувьд хөрөнгийн биржид итгэх итгэл нь хөдөө амьдардаг иргэдтэй харьцуулахад 8.5 пунктээр илүү, харин итгэдэггүй гэсэн хариулт нь 0.3 пунктээр бага, мэдэхгүй гэсэн хариулт 8.4 пунктээр бага байна. СЗХ-нд итгэх итгэл хотын иргэдийн хувьд 5.4 пунктээр өндөр байхад мэдэхгүй гэсэн хариулт нь 10.1 пунктээр бага байна.

Зураг 4. Санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл, нийт дүн



Санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийн тандах судалгаанд оролцогчдыг нас, хүйс, сууцны төрөл, хот хөдөө болон орлогын түвшингээр нь ангилан харахад ялгаатай дүр зураг харагдаж байгаа нь сонирхол татаж байна. Тухайлбал, боловсролын түвшин доогуур, амьжиргааны түвшин бага (гэр хорооллын эсвэл орлого бага) бүлгийн иргэд аливаа санхүүгийн байгууллагын үйл итгэдэг үү гэсэн асуултад мэдэхгүй гэдэг хариултыг их өгсөн байна.

Арилжааны банкнаас бусад байгууллагуудад иргэдийн итгэх итгэл наснаас хамааран ялгаатай байна. Өөрөөр хэлбэл 35 ба түүнээс доош настай болон 35-аас дээш настай гэсэн хоёр насны бүлэг үүсгэн эдгээр байгууллагуудад итгэх итгэл нь энэ хоёр бүлгийн хувьд ялгаатай эсэхийг шалгахад арилжааны банкнаас бусдынх нь хувьд 5 хувийн түвшинд ялгаатай гэж гарлаа. Эдгээр байгууллагуудад итгэх итгэл залуу хүмүүсийн дунд сайн байна.

Сууцны төрөл гэсэн хувьсагчийн хувьд СЗХ, хөрөнгийн бирж болон арилжааны банкинд итгэх итгэл нь ач холбогдол бүхий ялгаатай байна. Санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл орон сууцанд амьдардаг иргэдийн хувьд эсрэг бүлгийнхнээсээ илүү сайн байна. Эдгээр байгууллагуудад итгэдэг үү гэсэн асуултад мэдэхгүй гэсэн хариултыг гэр хороололд амьдардаг иргэд орон сууцанд амьдардаг иргэдтэй харьцуулахад нэлээд их өгчээ.

Тухайлбал, орон сууцанд амьдардаг иргэдийн 33.7 хувь нь СЗХ-д итгэдэг байхад

гэр хороололд амьдардаг иргэдийн хувьд 27.1 хувь нь итгэдэг гэжээ. Гэр хороололд амьдардаг иргэдийн бараг тал нь хөрөнгийн биржид итгэдэг үү гэсэн асуултад мэдэхгүй гэж хариулсан нь орон сууцанд амьдардаг иргэдтэй харьцуулахад 11.6 пунктээр өндөр байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийг боловсролын бүлгээр нь харахад бүх байгууллагуудын хувьд итгэх итгэл ач холбогдол бүхий ялгаатай. Бүрэн дундаас дээш боловсролтой иргэдийн хувьд СЗХ, хөрөнгийн бирж, ББСБ, ХЗХ, даатгалын компаниуд болон арилжааны банкинд итгэх итгэл нь эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад сайн байна. Бүрэн дундаас дээш боловсролтой иргэдийн хувьд 25.8 хувь нь итгэдэг гэжээ. Харин боловсрол доогуур бүлгийн иргэд мэдэхгүй гэсэн хариултыг аль ч байгууллагын хувьд илүүтэй өгсөн бөгөөд СЗХ-ны хувьд 49.8 хувь нь мэдэхгүй гэсэн нь боловсрол дээгүүр хүмүүстэй харьцуулахад 12.3 пунктээр илүү байна.

Иргэд орлогын түвшингээсээ хамааран санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл нь ялгаатай байгаа бөгөөд ялангуяа СЗХ болон хөрөнгийн биржийн хувьд ач холбогдол бүхий ялгаатай байна. Өрхийн нэг хүнд ногдох орлого нь сарын хоёр зуун мянгаас дээш иргэдийн хувьд хөрөнгийн биржид итгэх итгэл нь 38 хувь байхад бага орлоготой иргэдийн хувьд итгэх итгэл нь 14.2 пунктээр бага байна. Харин СЗХ-ны хувьд өндөр

ДҮГНЭЛТ

Санхүүгийн зах зээлийн оролцоог даатгал, зээл болон хөрөнгийн зах зээлийн хүрээнд авч үзэн, голчлон авдаг үйлчилгээ, санхүүгийн байгууллагын сонголтод нөлөөлдөг хүчин зүйлс болон оролцохгүй байгаа шалтгааныг тодорхойлсон.

Нийт иргэдийн 40.8% нь зээл авсан бөгөөд талаас илүү нь арилжааны банкнаас зээл авчээ. Иргэдийн авсан зээлэнд арилжааны банк дийлэнх хувийг эзэлсээр байна. Иргэдийн санхүүгийн байгууллагын сонголтод нөлөөлдөг хамгийн гол хүчин зүйлийн нэг нь үйлчилгээний түргэн шуурхай байдал байна. Гэвч санхүүгийн байгууллагын сонголтод нөлөөлдөг чухал хүчин зүйлс нь ялгаатай байна. Арилжааны банкны хувьд зээлийн хүү нэгдүгээр гол хүчин зүйл, ББСБ-ын хувьд танил тал, барьцаа хөрөнгө, баталгаанд тавигдах шаардлага дараагийн гол хүчин зүйлс болж байна.

4 удаагийн судалгааны үр дүнгээс харахад сайн дурын даатгалд хамрагдалт болон даатгалын талаарх мэдлэг нь хэрэглэгчийн нас, боловсрол, орлого болон сууцны нөхцлөөс хамааран өөр бөгөөд тодорхой зүй тогтолтой байна. Үүнд, 35-аас дээш настай, өндөр боловсролтой, орлого өндөртэй бөгөөд орон сууцанд амьдардаг иргэдийн хувьд даатгалд хамрагдалт өндөр бөгөөд мэдлэг сайтай байна.

Даатгалын талаар мэдэхгүй гэсэн хариулт судалгааг хийж эхэлсэн 2016 оны 3 улирлаас хойш буурч байсан бол 2018 оны 4 улирлын байдлаар бага зэрэг өссөн байна. Гэсэн хэдий ч 2016 оны 3 улирлын түвшингээс эрс бага байна. Тухайлбал, даатгалын талаар мэдэхгүй гэсэн хариулт 2016 оны 3 улирлын судалгаатай харьцуулахад 12.4 пунктээр

бага, 2018 оны 3 улиралтай харьцуулахад 1.8 пунктээр өндөр байна.

Иргэдийн 20 орчим хувь нь хөрөнгийн зах зээлд оролцохыг сонирхож байсан ч ердөө 5.4 хувь нь арилжаанд оролцож байжээ. Хөрөнгийн зах зээлд оролцон сонирхол бүлгүүдэд харилцан адилгүй байна. Хөрөнгийн биржийн арилжаанд оролцохгүй байгаа гол шалтгаанууд нь мэдээлэл байхгүй, хэрхэн оролцохоо мэдэхгүй гэж хариулсан.

Судалгаанд хамрагдсан иргэдээс санхүүгийн зохицуулагч байгууллагууд болон зуучлагч байгууллагуудад итгэх итгэлийг 2016 оны 3, 2017 оны 1 болон 2, 2018 оны бүх дөрвөн улирлуудад тандан асуусан. Судалгаа хийсэн энэ хугацаанд 2017 оны 2 улирлаас бусад бүх улирлуудад эдгээр байгууллагуудад итгэх итгэл харьцангуй тогтвортой байлаа. Учир нь судалгаа хийсэн 6 улирлаас ганц 2017 оны 2 улиралд бүх байгууллагуудад итгэх

итгэл маш өндөр гарч бусад 5 улирлынхаа дунджаас 7–24 пунктээр нэмэгдсэн. Гэтэл бусад 5 улирлын хувь эдгээр байгууллагуудад итгэх итгэл нь 5–9.5 пунктийн хооронд хэлбэлзэлтэй гарсан. Нийт судалгааны үр дүнгүүдээс харахад арилжааны банкинд итгэх итгэл хамгийн өндөр буюу дунджаар 80.9, үүний дараа даатгалын компани (57%), ББСБ (39.5%), Хөрөнгийн бирж (33%), СЗХ (27.8%), ХЗХ (27%) орж байна.

CV

WOCCU /World council of credit unions/



WOCCU буюу Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо нь олон улсын худалдааны холбоо, хадгаламж, зээлийн хоршоодын хөгжлийн агентлаг болон нөхөрлөл хоршооллын хэлбэртэй санхүүгийн байгууллагуудыг тэргүүлэн ажилладаг ба тэдний өмгөөллийн болон засаглалын тэргүүлэх дуу хоолой болсон байгууллага юм.

Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо нь өндөр чанартай, боломжийн үнэтэй санхүүгийн үйлчилгээг дэлхий дахинаа хүргэх зорилгын хүрээнд боловсрол, хамтын ажиллагаа, олон нийтэд тулгуурласан хөгжлийн төслүүдээр дамжуулан дэлхийн өнцөг булан бүрт үйл ажиллагаа явуулж буй нийт 6 тивийн 117 улсын 89,000 гаруй хадгаламж, зээлийн хоршоодын бие даасан, тогтвортой хөгжлийг дэмжин тэдгээрийн 260 сая гаруй гишүүдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгыг тавин ажиллаж байна.

Тус холбооны үүсэл нь 19 дүгээр зууны Европын зээлийн хоршоодоос улбаатай ба Franz Hermann Schulze–Delitzsch нь 1850–аад онд Герман улсад хамгийн анхны хадгаламж зээлийн хоршоог санхүүгийн үйлчилгээг хүртэх боломжгүй хүмүүст өөрсдийн болон хамтрагчдынхаа бий болгосон хадгаламжаас зээлэх боломжийг олгон байгуулж байсан юм. Friedrich Wilhelm Raiffeisen нь 10 жилийн дараа санхүүгийн хоршооллын ойлголтыг Германы хөдөө орон нутагт түгээсэн.

Хадгаламж, зээлийн хоршооны санаа нь Хойд Америкт 20 дугаар зууны эхээр өргөжсөн ба АНУ–ын Хадгаламж, зээлийн хоршооны үндэсний холбоо /CUNA/ нь 1934 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд 20 жилийн дараа CUNA–н ерөнхийлөгч, үүсгэн байгуулагч Roy Bergengren нь байгууллагаа Хойд Америкаас бусад орон руу тэлэх нэмэлт бодлогыг батласан. Энэхүү бодлогын зорилго нь дэлхийн хэмжээнд хөгжиж буй орнуудын хамгийн том хор хөнөөлтэй зүйл болох мөнгө хүүлэхтэй тэмцэх байсан ба алсын хараа нь хүмүүсийн эдийн засгийн асуудлыг дээшлүүлэхэд маш үр дүнтэй байсан.

1950–аад онд CUNA–аас гаргасан олон улсын хадгаламж, зээлийн хоршоодын хөгжлийн хөтөлбөр нь хамтын ажиллагааны хөгжилд түлхүү анхаарсан бөгөөд хэд хэдэн хувийн болон төрийн санхүүжилтийн агентлагтай хамтран хадгаламж, зээлийн хоршоог илүү том хөтөлбөрт дэмжлэг болгон буурай хөгжилтэй орнуудад орчин үеийн эдийн засгийг бий болгоно гэж зорьжээ. Европ болон Канадын хоршооллын системийн хүчин чармайлтаар энэхүү холбоо нь дараагийн 20 жилд дэлхий дахинд байгуулагдсан бүх хадгаламж, зээлийн хоршоог удирдсан юм.

1962–1970 оны хооронд АНУ, Канад болон Австралийн хадгаламж, зээлийн хоршооны хөдөлгөөн нь системтэйгээр тэлэх олон улсын хөдөлгөөнийг эхлүүлсэн. 1960–аад оны сүүлчээр дэлхийн хадгаламж, зээлийн хоршоод олон улсын хадгаламж зээлийн хоршооны өнөөгийн хэлбэрт шилжин орсон. Ингэснээр одоогийн Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо нь улс орнуудын үндэсний хадгаламж, зээлийн хоршоодын холбоодуудын санал дээр үндэслэн 1970 оны 11 дүгээр сарын 10–ны өдөр Висконсин

мужид байгуулагдсан бөгөөд албан ёсоор 1971 оны 1 дүгээр сарын 1–ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба олон улсын байгууллагуудын өмнө дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодыг төлөөлөн, хууль тогтоомж, зохицуулалтыг сайжруулах хүрээнд улс орны засгийн газруудтай хамтран ажилладаг байна.

Дэлхийн холбоо нь байгууллагынхаа гишүүдийг төлөөлөх захирлуудын зөвлөлөөр удирдуулдаг ба төв байгууллага болон салбарууд нь АНУ–ын Висконсин муж дахь Мадисон хотод байрладаг. Дэлхийн холбоо нь 2017 он гэхэд 117 орны 260 сая гишүүнтэй 89000 хадгаламж, зээлийн хоршоодод үйлчилдэг болтлоо тэлсэн байна. Дэлхийн холбоо нь олон улсын стандартад нийцсэн илүү сайн үр дүнд хүрэх, шаардлагагүй зохицуулалтын ачааллыг хязгаарлах орчны үйл ажиллагааг сайжруулахыг дэмжсээр ирсэн. 1971 оноос хойш ойролцоогоор 300 санхүүгийн бус тусламжийн хөтөлбөрийг дэлхий дахинд үзүүлсэн бөгөөд бүх үйлчилгээ нь хадгаламж зээлийн хоршоо болон бусад хамтрагч санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн байна.

Сүүлийн 10 жил дэх олон улсын томоохон хэмжээний банкуудын санхүүгийн хямралаас үүдэж илүү олон улсын дүрэм журмууд бий болоход хүргэсэн ба эдгээр дүрмүүд нь жижиг байгууллагууд ялангуяа хадгаламж, зээлийн хоршоо болон санхүүгийн хамтрагчдад дагаж мөрдөхөд хүндрэлтэй байгаа юм. 2017 онд Дэлхийн холбоо нь Basel–ийн хороотой хамтарч зохицуулалтын ачааллыг амжилттай бууруулсан байна.

2017 онд Австри, Венид болсон Дэлхийн хадгаламж зээлийн хоршооны хуралд 59 орны 1673 тэргүүлэгчдийг нэгтгэн цуглуулсан ба хурлын үеэр дижитал төлбөрийн хэв

маягт суралцаж, кибер сүлжээний аюулаас бизнесээ таслахгүй хамгаалах аргын талаар хэлэлцсэн байна. Мөн дэлхийн өнцөг булан бүрт программын оффистой бөгөөд тэдгээр нь гишүүний татвар, засгийн газрын агентлаг, сангийн буцалтгүй тусламж, бэлэг зэргээс санхүүждэг.

Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоонд 2017 оны байдлаар удирдах түвшний гишүүн орны 51 байгууллага, харьяа гишүүн орны 3 байгууллага болон хамтрагч гишүүн орны 62 байгууллага гишүүнчлэлтэй бөгөөд хамтрагч орны гишүүн байгууллага болох ACCU буюу Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоонд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо гишүүнчлэлтэй байдаг.



Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо нь 1971 онд байгуулагдсан ба өнөөдрийн байдлаар 26 орны ойролцоогоор 40.2 сая гишүүнтэй 45 мянган хадгаламж, зээлийн хоршоо, холбоодыг нэгтгэн ажиллаж байгаа юм. Азийн хадгаламж, зээлийн хоршоо нь ХЗХ-дыг нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэрэгсэл гэж үзэн тэдгээрийн тогтвортой хөгжил, хөдөлгөөний сурталчилгаанд чиглэн ажиллаж Азийн хоршоодыг хөгжилд чиглүүлэн, харилцаа холбоо, зохицуулалт, төлөөллийн үүргийг гүйцэтгэдэг. Мөн урт болон богино хугацааны техникийн туслалцаа, сургалт, мэдээллээр гишүүдээ хангадаг ба төлөвлөлт хөгжил, гишүүнчлэлийн үйлчилгээ, сурталчилгаа, маркетинг судалгаа, бизнес хөгжил, дэмжих үйлчилгээ гэсэн 6 үндсэн хэлтсээр дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг.

Мөн холбоо нь ард түмний эдийн засаг, нийгмийн сайн сайхан байдалд эерэг өөрчлөлт оруулахад санхүүгийн хоршоодын нөлөөллийг өргөжүүлэх үүднээс улс

орны үндэсний холбоо, зохицуулагч байгууллагууд, тэдгээртэй ижил төрлийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Түүнчлэн удирдах түвшний үйл ажиллагааг ерөнхий хурал болон төлөөлөн удирдах зөвлөлөөр дамжуулан хэрэгжүүлдэг. Ерөнхий хурал нь гишүүн байгууллагуудын албан ёсны төлөөлөгчдөөс бүрддэг ба гишүүд бүгд саналын эрхтэй бөгөөд Удирдах зөвлөлд сонгогдох боломжтой. Харин төлөөлөн удирдах зөвлөл нь Ерөнхий хурлаас 5 гишүүнийг захиралд сонгож ажиллуулдаг ба хоёр жилийн хугацаатай тухайн албан тушаалыг хашдаг байна.

ACCU –ийн асан гүйцэтгэх захирал Ранжет (Ranjith Hettiarachchi) болон одоогийн гүйцэтгэх захирал Еленита (Elenita V San Roque) нарын дэмжлэгтэйгээр 1999 онд “ХЗХ-ны тогтвортой хөгжлийн арга зам” сэдэвт сургалт явуулсанаас хойш Азийн Хадгаламж, зээлийн хоршоодын холбоо нь Монголын хадгаламж, зээлийн хоршоодыг олон улсын зарчмын дагуу хөгжүүлэх, хоршоодын үйл ажиллагааг сайжруулах, боловсронгуй болгох, ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм.



Монгол Улсад 1996 оноос хадгаламж, зээлийн хоршоод үүсгэн байгуулагдаж эхэлсэн ба 1998 онд 18 ХЗХ, 2001 онд 58 ХЗХ бий болсон юм. Ингэснээр анхны Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо (МХЗХҮХ) 1998 онд 9 ХЗХ-ны санаачлагаар байгуулагдсан бол 2001 онд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний нэгдсэн холбоо (МХЗНҮХ)

байгуулагдан зэрэгцэн үйл ажиллагаагаа явуулж байсан.

Харин Монгол Улсын хэмжээнд нэгдсэн ганц холбоотой байх нь зүйтэй гэсэн утгаар дээрх хоёр холбоо 2003 онд нэгдэж дээвэр байгууллагын нэгдсэн тогтолцоотой болсон тул Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо 2007 оны 6 сарын 29 –ний өдөр дахин шинэчлэгдэн үүсгэн байгуулагдсан.

2011 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр батлагдсан Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн дагуу тус холбоо нь 2012 онд Үндэсний гэсэн статусыг авсан юм. Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо нь ХЗХ-дыг олон улсын хоршооллын зарчмын дагуу ажиллуулах, чадавхыг сайжруулан тогтвортой хөгжүүлэх, хөгжлийн шинэ түвшинд гаргах талаар онцгой анхаарч, хамтын ажиллагааг өргөжүүлэн идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг.

Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо нь 2005 онд ACCU-д дэмжигч гишүүнээр элсэж, гишүүн байгууллагын хувьд Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбооноос зохион явуулдаг бүхий л арга хэмжээнд оролцож, хэрэгцээт дэмжлэгийг авч ирсэн. Монголын хадгаламж, зээлийн хоршоод жил бүрийн 9 дүгээр сард болдог Азийн хадгаламж, зээлийн хоршоодын форумд оролцож олон улсын зөвлөх, мэргэжилтнүүдээс суралцах, туршлага солилцох, дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын хөгжлийн чиг хандлагын талаар мэдээлэл авч байгаа юм.

2014 онд зохион байгуулагдсан Монголын ХЗХ-дын тогтвортой хөгжил сэдэвт Үндэсний анхдугаар форумд Азийн Хадгаламж, зээлийн хоршоодын холбоог төлөөлж менежер Еленита В. Сан Роке (Elenita V San Roque) “Тогтворжилтын болон хадгаламж, хамгаалалтын сан” сэдэвт илтгэл тавьж оролцсон.



ӨРГӨН ДУРАН

САЯХАН ТАЙЛАНД УЛСАД АЗИ ДАХЬ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ФОРУМ БОЛЖ ӨНГӨРЛӨӨ. ТУС УУЛЗАЛТЫН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДЛЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ӨГНӨ ҮҮ.

Тайландын Вант Улсын Бангкок хотноо 2019 оны 01 дүгээр сарын 22–ноос 23–ны өдөр Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс Ази дахь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд салбартаа тэргүүлэгч хөгжлийн санхүүгийн байгууллагууд болон нөлөө бүхий хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилго бүхий “Азийн санхүүгийн байгууллагын форум 2019” анхны чуулга уулзалт зохион байгуулагдсан. Тус форумар өрийн хэрэгслээр дамжуулан хөрөнгө босгох, хувьцаагаар хөрөнгө оруулалт хийх, техник туслалцааны хөтөлбөр хэрэгжүүлэх боломжуудын талаар нэгдсэн хэлэлцүүлэг, Азийн улс орнуудын эдийн засаг, хөрөнгө оруулалтын орчны талаар дэд хэлэлцүүлгүүд тус тус болж өнгөрсөн. “Азийн санхүүгийн байгууллагуудын форум 2019” нь улс орнуудын эдийн засгийн нөхцөл байдал, тогтвортой хөгжлийг хангахад чиглэж буй бодлого, хөтөлбөрүүд, мөн санхүүгийн зах зээл, хөрөнгө оруулалтын боломж, хууль эрхзүйн орчны талаар гадны хөрөнгө оруулагч иргэд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өгөх, түүнчлэн хөрөнгө оруулах болон хөрөнгө оруулалт татах сонирхолтой иргэд, аж ахуйн нэгжүүдийг холбох гүүр болсон гэдгээрээ онцлог байлаа.

ФОРУМЫН ЦАР ХҮРЭЭ ХЭР ЗЭРЭГ ТОМ БАЙСАН БЭ? ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ӨГНӨ ҮҮ.

Уулзалтад 39 улсын 194 хөрөнгө оруулагчид, 302 хөрөнгө оруулалт татах сонирхолтой аж ахуйн нэгжүүд, 50 гаруй бодлого зохицуулалтын байгууллагууд болон санхүүгийн байгууллагуудаас төлөөлөн ирсэн панелистууд оролцсон. Арга хэмжээний хүрээнд бодлого зохицуулалтын байгууллагууд болон санхүүгийн байгууллагуудын төлөөлөл талаас Ази дахь улс орнуудын санхүүгийн зах зээл болон эдийн засгийн талаарх нөхцөл байдлын талаар мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулалтын боломжуудын талаар ярилцлага өрнүүлсэн. Түүнчлэн хөрөнгө оруулагчид болон хөрөнгө оруулалт татах сонирхолтой этгээдүүдийг холбох, тэдгээрийн харилцаа холбоог идэвхижүүлэх арга хэмжээ мөн зохион

байгуулагдсан.

ТУС АРГА ХЭМЖЭЭНД САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ЯМАР ХЭЛБЭРЭЭР ОРОЛЦСОН БЭ? ӨӨР ЯМАР БАЙГУУЛЛАГУУДААС ПАНЕЛИСТААР ОРОЛЦСОН БЭ?

Санхүүгийн зохицуулах хорооны хувьд Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн талаарх дэд хэлэлцүүлэгт панелистаар оролцсон бөгөөд тус хуралдаанаар Монгол Улсын эдийн засгийн өсөлт, ирээдүйн чиг хандлагын талаарх хүлээлт, тогтвортой өсөлтийг хангах үл хөдлөх хөрөнгийн зах зээл болон бусад дэд сектор дахь хөрөнгө оруулалтын боломж, түүнчлэн санхүүгийн салбар дахь хүртээмжтэй өсөлтийг хэрхэн хангах талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн. Монгол Улсын эдийн засаг болон санхүүгийн зах зээлийн талаарх дэд хэлэлцүүлэг форумын эхийн өдөр буюу 2019 оны 01 дүгээр сарын 22–ны өдөр зохион байгуулагдсан. Тус хэлэлцүүлэгт модератороор “Монголын тогтвортой хөгжил партнер” ХХК–ийн үүсгэн байгуулагч Л.Болормаа, панелистаар “Голомт банк” ХХК, “Би Ди Эм хөрөнгө оруулалтын менежмент ҮЦК” болон Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллүүд оролцсон.

МОНГОЛЫН УЛСЫН ТАЛААРХ ДЭД ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЕЭР ЯМАР АСУУДЛУУДЫН ТАЛААР ГОЛЧЛНӨХОН ХЭЛЭЛЦСЭН БЭ?

Хурлын үеэр Голомт банкны төлөөлөгч Монголын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал болон олон улсын байгууллагуудаас гаргаж буй эдийн засгийн өсөлтийн таамаглал, эдийн засгийн бүтэц, салбаруудын талаар танилцуулсан. Харин “Би Ди Эм хөрөнгө оруулалтын менежментийн ҮЦК”–ийн төлөөлөгчийн хувьд тогтвортой өсөлтийг хангах төсөл хөтөлбөрүүдийн талаарх танилцуулга хийсэн. Тус компани нь “Монгол улсын хөгжлийн банк”–ны охин компани бөгөөд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд уул уурхай, дэд бүтэц, ногоон хөгжил, хөдөө, аж ахуйн салбарт чиглэсэн томоохон хөгжлийн болон өгөөж бүхий төслүүдэд хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулалтын сангуудыг байгуулан ажилладаг.



Хэлэлцүүлгийн үеэр гэр хорооллын өрхийг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй төслүүдийн талаар түлхүү дурдсан. Модераторын зүгээс санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэг болон

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгт ямар оролцоотой байгаа талаар, мөн тус нийгэмлэгийн “Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн санхүүгийн хүртээмжийн зөвлөл”–ийн талаарх асуултыг тавьсан.

ТАНЫ ДУРДСАНЧЛАН “ЗҮҮН ЕВРОП, ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ЗӨВЛӨЛ” САЯХАН ШИНЭЭР ҮҮСГЭН БАЙГУУЛАГДААД УДААГҮЙ БАЙГАА. ЭНЭХҮҮ ЗӨВЛӨЛ НЬ ЯМАР ЧИГ ҮҮРЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН БЭ?

Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн санхүүгийн хүртээмжийн зөвлөлийн дүрмийг ОХУ–ын Сочи хотод 2018 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан “Санхүүгийн Хүртээмжийн Нийгэмлэгийн Дэлхийн Бодлогын Чуулган”–ы үеэр баталсан. Тус зөвлөл нь санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн 5 дахь бүс нутгийн зөвлөл болж байгаа ба зөвлөлийн гишүүд бүс нутгийнхаа санхүүгийн хүртээмжтэй холбоотой асуудал, сорилтуудад түлхүү анхаарал тавьж хамтран ажиллах юм. Ингэснээр бүс нутгийн онцлогийг санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн зорилготой уялдуулж, гишүүд илүү зохистой, ач холбогдолтой бодлого боловсруулах нөхцөл дарааллийг бүрдүүлнэ. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь эцэслэн боловсруулагдаагүй боловч төлөвлөгөө нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, цахим санхүүгийн үйлчилгээ буюу финтекийг хөгжүүлэх гэсэн хэсгүүдээс бүрдэх ба дэд ажлын хэсгүүд байгуулагдаад байна. Цаашид гишүүд эдгээр чиглэлүүдийн хүрээнд чухал шаардлагатай арга хэмжээг эрэмбэлэн тодорхойлж, хамтран ажиллахаар тохиролцоод байна. Монгол Улсын хувьд дэд ажлын хэсгүүдэд орж ажиллан, зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцохоор төлөвлөж байна.

ХЭРЭГЛЭГЧ



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД ХҮРГЭХ ЗӨВЛӨМЖ

Санхүүгийн хэрэглэгч зарим тохиолдолд санхүүгийн гэрээний нөхцлүүдтэй танилцаж, бүрэн гүйцэд таних боломжгүй байдаг тул тусгай зөвшөөрөл бүхий санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага тухайн хэрэглэгчийг шийдвэр гаргахад нь шаардлагатай, үнэн зөв мэдээллээр хангах үүрэгтэй бөгөөд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдэд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖ

Санхүүгийн үйл ажиллагаа нь хоёр талт гэрээний харилцаагаар зохицуулагддаг тул үйлчлүүлэгчид гэрээ болон түүний хавсралтад заасан нөхцлүүдтэй сайн танилцалгүйгээр санхүүгийн гэрээг байгуулахгүй байх, санхүүгийн байгууллагын ажилтнаас уг гэрээтэй дэлгэрэнгүй танилцах боломж олгохыг хүсэх;

Санхүүгийн үйлчилгээний гэрээг баталгаажуулсны дараа уг гэрээнд заасан өөрийн хүлээх үүргийг хариуцлагатайгаар мөрдөж, биелүүлэх;

Санхүүгийн гэрээ, аливаа төлбөр болон даатгалын нөхөн төлбөртэй холбоотой холбогдох баримтуудыг хадгалах;

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, санхүүгийн гэрээний маргаантай асуудал үүссэн тохиолдолд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандаж, шийдвэрлүүлэх, улмаар шаардлагатай гэж үзвэл Санхүүгийн зохицуулах хороонд хандан зөвлөгөө авах, холбогдох маягтын дагуу өргөдөл бичиж, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу урьдчилан

шийдвэрлүүлэх;

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбоотой маргаантай асуудлаар Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах;

Хэрэв маргаантай асуудлаар гаргасан шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах.

ДААТГУУЛАГЧ

Гэрээний нэгдсэн загварт баригдалгүйгээр өөрт тань тохирох тусгайлсан нөхцлийг санал болгож, харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээ байгуулах;

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбогдох маргааныг Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд хандан урьдчилан шийдвэрлүүлэх, хэрэв уг шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ

Зээл олгогч бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн санал болгож буй гэрээний нөхцлүүдтэй харьцуулж, зээлийн дүн, зээлийн хүү болон нэмэгдүүлсэн хүү, зээлийн эргэн төлөлтийн хуваарьтай танилцсаны эцэст сонголт хийж, шийдвэр гаргах;

Зээлийн даатгал нь албан журмын даатгалын төрөлд хамаарахгүй бөгөөд зөвхөн үйлчлүүлэгчийн зөвшөөрлийн үндсэн дээр

байгуулахыг анхаарах;

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд зааснаар зээлдэгчийн зээлийн дансанд гүйлгээ хийгдсэнээр зээлийг олгосонд тооцох тул зээл, харилцах дансны орлого, зарлагын гүйлгээг бэлэн бус хэлбэрээр хийх;

Зээлийн гэрээг дуусгавар болгосон тохиолдолд зээлдүүлэгчээс гэрээний үүргийн гүйцэтгэл хангагдсан талаарх тодорхойлолт авч, Зээлийн мэдээллийн сан болон Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн байгууллагад шаардлагатай бүртгэлийг хийлгэх;

Зээлийн гэрээнд санхүүгийн байгууллагын зүгээс санхүүгийн хэрэглэгчид мэдэгдэлгүйгээр дангаараа гэрээг цуцлах, гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах зэргээр үйлчлүүлэгчийн эрхийг хөндсөн зүйл, заалт байгаа эсэхийг анхаарах;

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулиар зээлийг заасан хугацаанд төлөөгүй бол зээлийн гэрээний үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд зээлийн үндсэн хүү, гэрээнд заасан бол түүний хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр зохицуулсан байгааг анхаарах.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ /ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ/

Хөрөнгө оруулахаас өмнө дараах зүйлсийн талаар анхаарах:

- Хөрөнгө оруулалтын зорилго;
- Ямар мөнгөөр хөрөнгө оруулалт хийх вэ?
- Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээ;
- Ямар хугацаанд, хэр идэвхтэйгээр хөрөнгө оруулалт хийх?

Өөрийн хэрэгцээ, шаардлагыг хангасан гэж үзсэн үнэт цаасны компанийг сонгон үйлчлүүлэх;

Хувьцааг нь эзэмшиж буй компанийн үйл хэрэгт /хувьцаа эзэмшигчдийн хуралд/ идэвхтэй оролцох;

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн данс дахь үнэт цаас, бэлэн мөнгөний үлдэгдэлдээ хяналт тавьж байх, шаардлагатай тохиолдолд тодорхой хугацаанд дансны гүйлгээг түр зогсоох, царцаах.

Б.Лхагвасүрэн: ХУВЬЦААНЫ ҮНЭ ХЭЛБЭЛЗЭЛТЭЙ БАЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД АШИГТАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Лхагвасүрэнтэй ярилцлаа.



–Банк бус санхүүгийн байгууллага олон нийтээс хөрөнгө татаж нээлттэй хувьцаат компани болж байна. Эдийн засагт нөлөөлөх өгөөжийг тайлбарлаж өгөхгүй юу?

–Өнөөдөр Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн сарын хүү 3–3.5 хувийн хүүтэй. жилийн 36–42 хувийн хүүтэй байгаа. Гэхдээ иргэн, аж ахуйн нэгж хэзээ ч банк бусаас банкнаас авдаг шиг жилийн хугацаатай зээл авдаггүй. Яагаад гэхээр тухайн хүний санхүүгийн хэрэгцээг хангаж буй богино хугацааны эргэлтийн хөрөнгийн зээл учраас тэр. Өөрөөр хэлбэл, иргэн, аж ахуйн нэгж импортоор бизнес хийе гэхэд 500 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хэрэгтэй бол хурдан хугацаанд сар эсвэл хоёр сарын хугацаанд борлуулаад банк бусаас авсан зээлээ эргүүлээд төлөх л асуудал.

Энэ бизнесээ ойролцоогоор 25 хувийн ашигтай гэж тооцоход хоёр сарын хугацаатай зээл авахад долоон хувийн хүүтэй зээлнэ. Зардал нь долоон хувь, ашиг нь 18 хувьтай бизнес хийсэн гэсэн үг. Банкнаас тавьдаг шалгуур, судалгааг авч үзэхгүйгээр бизнест нь анализ хийж үзээд өгдгөөрөө онцлогтой. Хүмүүсийн санхүү, бизнесийн хэрэгцээг богино хугацаанд шийдвэрлэх зах зээлийн эрэлт байгааг харгалзан төрөөс үүнийг хяналттайгаар зохицуулах үүднээс манай байгууллагаас ББСБ–ын тусгай зөвшөөрлийг олгодог.

–Барьцаат зээлийн үйлчилгээний газрууд ББСБ болоход юу нөлөөлөв?

–2014 оноос ББСБ–ын тоо өссөн. 2010 онд 250 орчим байсан бол одоо 500 болж нэг дахин өссөн. Мөн 2016 онд банк бусын

дүрмийн санг 400 сая төгрөг байсныг 2.5 тэрбум болгож өсгөсөнтэй холбоотой. Дүрмийн санг өсгөснөөр дээрх тоог багасгасан. Ингэснээр хүү буурч эхэлсэн. Хүртээмж нь нэмэгдсэн. Өмнө нь нэг барилгын компани нэг банк бусаас 400 сая төгрөг зээлээд авчих жишээтэй. Олон хүнд хүртдэггүй байв. Түүнчлэн зардлын ялгаа их.

Дүрмийн сан нэмэгдэх хэрээр эрсдэл хүлээх чадвар, ашиг орлого нь сайжирч мэргэжлийн хүмүүс зайлшгүй шаардлагатай болж жижиглэн болон бөөний зээлд шат дараалалтай зээлийн хүү нь буурч байгаа юм. Нөгөө талаар иргэдэд санхүүгийн мэдлэгтэй хүн үйлчилснээр тэдний санхүүгийн сахилга батыг шалгаж, өрхийн санхүүгээ зөв удирдах мэдлэг, мэдээлэл, зөвлөгөө өгч эхэлсэн нь эерэг нөлөө үзүүлж байх жишээтэй.

2012–2014 онд ломбардын хэлбэртэй ажиллаж байсан газрууд бүгд Банк бус санхүүгийн байгууллага болсон. Тухайн үед ломбард хэт олширч сөрөг нөлөө тэр хэрээр байсан. Тиймээс ломбард шиг банк бус биш, банк шиг банк бус байх шаардлага тавьж дүрмийн санг өсгөсөн нь эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлсэн.

–Одоо тэгвэл банк бусууд Хөрөнгийн биржид IPO хийж байна гэдэг нь санхүүгийн зах зээлд өрсөлдөөн нэмэгдэж байна гэж харж болох нээ?

–Одоогоор томоохон өөрийн хөрөнгөтэй банк бус хүмүүсээс хадгаламж хэлбэрээр итгэлцэл дээр хөрөнгө татан төвлөрүүлж байна. Тухайлбал, иргэний 100 сая төгрөгийг арван сар эргэлдүүлнэ. Танд арван сарын дараа төдөн хувийн хүүтэй буцааж өгнө гэсэн

нөхцөлөөр итгэлцлийн гэрээ хийж байгаа юм. Гэтэл Банк бус санхүүгийн байгууллагаас зээл авах эрэлт их байгаа учраас эх үүсвэр хэрэгтэй болж байна.

Зээлийн үйл ажиллагаа явуулахын тулд хэн нэгнээс зээл авч түүгээрээ дахин зээлийн үйлчилгээ үзүүлнэ гэсэн ойлголт байж болохгүй. Өөрөөр хэлбэл, зээлийн хөрөнгөөр дахин зээл өгнө гэдэг нь энэ байгууллага цааш өсөхгүй. Эдийн засагт ч ахиц үзүүлэхгүй. Тиймээс өөр төрлийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтыг хайж эхэлдэг. Үүний нэг нь олон нийтээс хөрөнгө татах явдал. Хэрэв та итгэж байвал манай хувьцааг худалдан авч хамтран ажилла.

Олон нийтэд нээлттэй компани болж ажилласнаар хоёр талдаа боломж олгож байгаа гэсэн үг. Өөрийн хөрөнгийн өгөөж ойролцоогоор 15 хувьтай гэж бодоход олон нийтээс хөрөнгө татахад энэ өгөөж 25 хувь болж өснө. Богино хугацааны эргэлтийн хөрөнгүүдийг илүү бага хүүтэйгээр олгож санхүүгийн хүртээмжийг олон хүнд хүртээж байгаа юм.

–Банк бусыг иргэд илүү их сонирхож байна. Өнгөрсөн оны сүүлээр “Лэндмн” IPO хийсэн бол дөнгөж саяхан “Ард Кредит” ББСБ олон нийтэд хувьцаагаа санал болголоо. Энэ хоёрыг финтек хөрөнгийн зах зээлийн анхдагч гэдгээр онцолж байна?

–Иргэд илүү их сонирхож байгаагийн нэг шалтгаан нь банкныг бодоход хурдан зохицуулалт хийдгээрээ илүү. Нөгөөтэйгүүр хувьцаа нь хувьцаа эзэмшигчдийн өөрсдийнх нь хөрөнгө учраас илүү итгэлтэй болж байна гэсэн үг. Хөрөнгө оруулалтын өгөөжийн

тооцооллуудыг илүү харж байна. Түүнчлэн IPO хийж, олон нийтийн компани болсноор финтек зах зээлтэйгээ холбоотой. Ирээдүй финтек рүү явж байгаа гэдэг нь тодорхой. Үүнийг олон нийт мэдэж эхэлсэн.

Цаашдаа энэ зах зээл рүү хөгжих нь гэдгээр хүмүүс хөрөнгө оруулалт хийж буй юм. Энэ нь ББСБ-ын хөрөнгийн зах зээлд гарч ирж буй нэг давуу тал нь. “Лэндмн” хөрөнгийн зах зээлд анх гарч ирсэн старт апп компани. Төлөвлөсөн татан төвлөрүүлэх хөрөнгөөс нь давж хөрөнгө төвлөрсөн. Энэ байдал нь дараагийн IPO хийх байгууллагуудад нөлөөлсөн. Эдний араас Хөрөнгийн биржид гарсан компаниуд ихэвчлэн олон жил үйл ажиллагаа явуулсан уламжлалт бизнестэй

даатгалын, хөдөө аж ахуй, барилгын компаниуд байлаа. Эдгээрт итгэх итгэл олон нийтийн зүгээс илүү байгаа нь ажиглагдсан.

–Хувьцааны үнийг хатуу эсвэл хэлбэлзэлтэй тогтоох хоёрын ялгаа нь юу вэ. Тухайлбал, “Лэндмн” 200 төг гэж байсан бол “Ард Кредит” 75–80 төгрөг гэжээ. Илүү гарсан хөрөнгө оруулалтыг буцааж өгөх тохиолдол “Лэндмн”-д гарсан гэж байсан?

–Жил ирэх тусам Хөрөнгийн биржид IPO гаргаж байгаа компаниудыг ажиглаж байхад үнээ тогтоох аргачлал, үнэлгээ нь улам сайжирч байна. Жишээлбэл, “Лэндмн”-д олон нийтээс таван тэрбумыг босгох байсан. Гэтэл найм дахин их буюу 40 гаруй тэрбум төгрөг төвлөрсөн. Тухайн үед шинэ

бүтээгдэхүүн хөрөнгийн зах зээлд гарч ирсэн болохоор нөлөөлсөн байх.

Түүнчлэн биржийн бүртгэлийн журам зааварт асуудал байснаас гадна хугацааны сүүлийн өдөр иргэд бөөнөөрөө шийдвэр гаргаж орж ирсэн нь хүндрэлтэй байсан. Энэ бүгдээс арилжааны журамд өөрчлөлт оруулж үнийг 15–20 хувийн хэлбэлзэлтэй тогтоосон. Түрүүлж санал хэлж байгаа хүнд сонголтыг илүү тавих гэх мэтээр өөрчлөлт оруулсан. Эрэлт ихэсвэл тухайн хувьцааны үнэ 15–20 хувийн нэмэгдэлтэй. Энэ журмын дагуу “Ард Кредит” ББСБ хувьцааны үнийг иргэдэд илүү сонголттой байдлаар тогтоосон.

**Ярилцсан Ц.Мягмарбаяр
 (“Зууны мэдээ” сонин)**

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ 2,511.8 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРЧ ӨНГӨРСӨН ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД 2.9 ХУВИАР ӨСЛӨӨ.

2018 оны жилийн эцсийн байдлаар Монголын хөрөнгийн зах зээлд Үнэт цаасны арилжаа эрхлэх 2, төлбөр тооцооны 1, төвлөрсөн хадгаламжийн 1 байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн 17 компани, 12 хувийн хөрөнгө оруулалтын сан, 3 кастодиан банк, 54 үнэт цаасны компани тус тус үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Хороонд бүртгэлтэй нийт 305 хувьцаат компани байна.


Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,511.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 71.5 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт ЗЗҮ-г 2018 оны жилийн эцсийн ДНБ-д харьцуулахад 7.8 хувьтай тэнцэж байна. Тайлант онд өссөн дүнгээр нийт 210.3 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж хөрвөх чадвар өнгөрсөн оноос 5.2 пунктээр өсөж 8.4 хувьд хүрлээ.

2018 оны 4 дүгээр улирлын байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “Монголын үнэт цаасны бирж” ХХК-аар дамжуулан нийт 245.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь түүхэн дэх хамгийн өндөр дүн бүхий арилжаа болсон юм. Нийт арилжааны дүнг задлан авч үзвэл, МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 31.4 төгрөгийн хувьцаа, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 178.6 тэрбум

төгрөгийн хувьцаа, 33.5 тэрбум төгрөгийн ЗГҮЦ, 631.6 сая төгрөгийн компанийн бонд, МҮЦБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 1.0 тэрбум төгрөгийн компанийн бонд, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 292.1 сая төгрөгийн хувьцаа, 66 сая төгрөгийн бондыг тус тус арилжаалав. Хувьчлан авч үзвэл нийт арилжааны дүнд эзлэх хувьцааны гүйлгээний дүн 85.7 хувь, ЗГҮЦ-ны гүйлгээний дүн 13.6

хувь, компанийн бондын гүйлгээний дүн 0.7 хувь байна.

Тайлант үед ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 729.8 нэгжээр буюу 3.5 хувиар өсч 21,466.8 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 21,737.7 нэгж, доод үзүүлэлт 18,861.36 нэгж, дундаж үзүүлэлт 20,157.00 нэгж байна.



Хөдөө аж ахуй, түүхий эдийн зах зээлд арилжаа эрхлэх 1 байгууллага, түүхий эдийн 12 брокер үйл ажиллагаа явуулж байна. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК 2018 онд нийт 157 удаагийн арилжааг зохион байгуулж 711.4 тэрбум төгрөгийн арилжаа

хийгдсэн бөгөөд энэ нь хамгийн өндөр дүн бүхий арилжаа боллоо. Нийт арилжааны дүнгийн 83.1 хувийг ямааны ноолуур, 8.4 хувийг завод ноос, 7.9 хувийг хонины ноос, 0.6 хувийг тэмээний ноос, 0.1 хувийг бодын хөөвөр тус тус эзэлж байна.

ДААТГАЛЫН САЛБАРЫН НИЙТ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ ӨМНӨХ ОНООС 35,6 ХУВИАР ӨСӨЖ 331.9 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРЛЭЭ.


Тухайн зах зээлийн хэмжээг илэрхийлэх гол үзүүлэлтүүдийн нэг болох нийт хөрөнгийн хэмжээ даатгалын салбарын хувьд өмнөх оны мөн үеэс 35.6 хувиар тус тус өсөж 331.9 тэрбум төгрөгт хүрсэн. Даатгалын салбарт давхар даатгалын нэг компани нэмэгдсэнтэй холбоотойгоор даатгалын салбарын хөрөнгийн бүтцэд өөрчлөлт гарсан ба давхар даатгалын нийт хөрөнгийн

салбарын үзүүлэлтэд эзлэх хувь хэмжээ өнгөрсөн оны мөн үед 17.7 хувь байсан бол тайлант улирлын байдлаар 21.2 хувь болж өслөө. Салбарын нийт хөрөнгийн 76.2 хувийг ердийн даатгалын компаниудын хөрөнгө, 2.7 хувийг давхар даатгалын компанийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Харин нийт хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 23.8 хувиар өсөж 178.7 тэрбум төгрөг болов. Энэхүү өсөлтийн 99 хувийг ердийн даатгалын компаниудын нийт хураамжийн орлогын өсөлт бүрдүүлэв. Хураамжийн орлогын төвлөрүүлэлтийг

авч үзвэл даатгалын зуучлагчид 39.8 тэрбум төгрөг буюу 22.3 хувийг, даатгалын төлөөлөгчид 36.9 тэрбум төгрөг буюу 20.6 хувийг бүрдүүлсэн байна.

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал тайлант улиралд 58.2 тэрбум төгрөгт хүрч, нийт хураамжийн орлогын 32.6 хувийг эзлэв. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 28.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 98.1 хувийг бүрдүүлж байна.



Даатгалын компаниуд өөрийн хүлээж авсан эрсдэлээ шилжүүлэх зорилгоор өөр нэгэн даатгалын компаниас давхар даатгалын үйлчилгээг авдаг. Манай орны хувьд дийлэнх даатгалын компаниуд гадны давхар даатгалын компанид эрсдэлээ даатгадаг ба тайлант улиралд даатгалын компаниуд нийт 55.3 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн зардалтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт хураамжийн орлоготой харьцуулахад 31 хувь байна.

Тайлант улиралд даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39.7 хувиар өсөж 18.4 тэрбум төгрөг болсон байна. Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 13 хувь, нийт хөрөнгийн өгөөж 5.6 хувь байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН НИЙТ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР 1.3 ИХ НАЯД ТӨГРӨГТ ХҮРЧ ӨМНӨХ ОНООС 32.5 ХУВИАР ӨССӨН БАЙНА.

2018 оны жилийн эцсийн байдлаар

санхүүгийн зах зээлд нийт 539 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын Хорооноос олгодог тусгай зөвшөөрлийн дагуу эрхлэх 10 төрлийн үйлчилгээ байгаагаас тайлант онд нийт байгууллагуудын дийлэнх нь буюу 91.3 хувь нь зээлийн үйл ажиллагааг дагнан болон хавсран эрхэлж, 8.7 хувь нь зөвхөн гадаад валют арилжааны үйлчилгээг дагнан эрхэлж байна.

Санхүүгийн байгууллагуудын чадавх, хэмжээг илэрхийлэгч хамгийн чухал үзүүлэлтүүдийн нэг болох нийт хөрөнгийн хэмжээ жилийн эцсийн байдлаар 1.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 32.6 хувиар өссөн байна. Активын бүтцээс харвал салбарын хөрөнгийн өсөлтийн 73.2 хувийг зээлийн өсөлт, пассивын бүтцээс харвал өөрийн хөрөнгийн өсөлтийн 66.3 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт тус тус бүрдүүлж байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн нийт үлдэгдэл өмнөх оноос 36.2 хувиар өсөж,

869.2 тэрбум төгрөгт хүрлээ. Нийт зээлийн үлдэгдлийн 81.9 хувийг иргэдийн зээл, 18.1 хувийг хуулийн этгээдийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа бол, 86.6 хувийг хэвийн зээл, 3.8 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 9.6 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. 2017 онд салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 12.7 байсан бол тайлант онд уг үзүүлэлт 3.2 нэгжээр буурч, зээлийн чанар сайжирсан байна.


Мөн салбарын зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн үйлчилгээний хүртээмж сайжирсан бөгөөд салбарын зээлдэгчдийн тоо өмнөх оноос 2.2 дахин нэмэгдэж 234.1 мянгад хүрч харин харилцагчдын тоо 1.1 дахин нэмэгдэж 1.6 саяд хүрсэн дүнтэй байна. Харин зээлийн бүтээгдэхүүний үнэ болох сарын жигнэсэн дундаж хүүгийн түвшин оны эцсийн байдлаар 3.2 хувьтай байгаа ба өмнөх оны түвшнээс 0.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант жилд банк бус санхүүгийн байгууллагууд 101.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан ба нийт банк бус

санхүүгийн байгууллагуудын 85.5 хувь нь 109.0 тэрбум төгрөгийн ашигтай, 12.1 хувь нь 7.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан

байна. Салбарын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд болох нийт хөрөнгийн өгөөж 9.0 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 11.7 хувьтай

байгаа ба өмнөх оноос 1.4, 1.7 хувиар тус тус өссөн дүнтэй байна.



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН НИЙТ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ 200.2 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРЧ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 30.7 ХУВИАР ӨСЧЭЭ.

2018 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 279 хоршоо, нийт 27 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Хоршоодын нийт гишүүдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 12.5 хувиар өсөж тайлант онд 62,556 боллоо.

Тайлант онд хадгаламж, зээлийн хоршоодын нийт хөрөнгийн хэмжээ 200.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 30.7 хувийн өсөлтийг үзүүлжээ. Энэхүү үзүүлэлт нь 2017 оны 35.4 хувийн өсөлтөөс бага хэдий ч сүүлийн 10 жилийн хугацаанд гарч буй гучаас дээш хувийн өндөр өсөлт юм. Салбарын нийт хөрөнгийн 83.3 хувийг нэг тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 21 ХЗХ, 13.2 хувийг 100 саяас нэг тэрбум хөрөнгөтэй


124 ХЗХ, үлдсэн буюу 3.5 хувийг 100 саяас доош хөрөнгөтэй 134 ХЗХ-д бүрдүүлж байна. Салбарын активын бүтцээс харвал нийт хөрөнгийн өсөлтийн 60.7 хувийг зээлийн өсөлт, пассивын бүтцээс харвал 89.6 хувийг хадгаламжийн өсөлт тус тус бүрдүүлж байна.

Салбарын нийт зээлийн үлдэгдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 27.2 хувиар өсөж 133.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин цэвэр зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 27.5 хувиар өсөж 130.2 тэрбум төгрөг, зээлийн эрсдэлийн сан 16.7 хувиар өсөж 3.6 тэрбум төгрөгт хүрчээ. Мөн нийт зээлийн 92.2 хувийг хэвийн зээл, 3.3 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 4.5 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.3 пунктээр өсөж 4.5 хувьд хүрчээ.

Мөн салбарын нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 42.5 хувиар өссөн бөгөөд түүний 98.3 хувийг хугацаатай хадгаламж, 1.7 хувийг хугацаагүй хадгаламж

бүрдүүлж байна. Хадгаламжийн энэхүү өсөлт нь 2017 оны мөн үеийн өсөлтөөс 4.7 пунктээр бага хэдий ч сүүлийн 10 жилд 40-өөс дээш хувиар өсөж буй өндөр үзүүлэлт юм.

Тайлант онд хоршоодын нийт орлого өмнөх оны мөн үеэс 29.6 хувиар өсөж 41.2 тэрбум төгрөгт хүрсэн бол цэвэр ашгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 3.7 хувиар буурч 5.3 тэрбум төгрөг боллоо. Салбарын хэмжээнд нийт 279 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаагаас 198 ХЗХ нь 5.6 тэрбум төгрөгийн ашигтай, 73 ХЗХ 0.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 8 ХЗХ тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй байна. Түүнчлэн ХЗХ-дын өөрийн хөрөнгийн өгөөж 16.7 хувь, нийт хөрөнгийн өгөөж 3.0 хувь байгаа бол гишүүдэд олгож буй зээлийн хүүгийн орлогын нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр өсөж 29.6 хувьд хүрчээ.



2019 ОНД БОЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

3 ДУГААР САРЫН 1

СХН Дэлхийн Санхүүгийн Бодлогын Манлайлагчдын Дээд Хэмжээний Чуулган, Бүгд Найрамдах Кот-Дивуар Улс.

3 ДУГААР САРЫН 11-14

СХН-ийн ажлын хэсгийн уулзалтууд, Арабын Бүгд Найрамдах Египет Улс

3 ДУГААР САРЫН 25-29

АFI –ийн ажлын хэсгийн уулзалтууд, Бахамын Хамтын Нөхөрлөл

2 ДУГААР САРЫН 27

Хүртээмжтэй даатгалын асуудлаарх харилцан мэдлэг, туршлага солилцох сүлжээний Блокчэйны Инновац сэдэвт уулзалт, Бүгд Найрамдах Филиппин Улс

4 ДУГААР САРЫН 1-5

СХН-ийн ажлын хэсгийн уулзалтууд, Бүгд Найрамдах Замби Улс

4 ДУГААР САРЫН 10,11

СХН болон Жи24-ийн Бодлого боловсруулагчдын ээлжит дугуй ширээний уулзалт, АНУ

5 ДУГААР САРЫН 13-17

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын 44 дүгээр ээлжит чуулга уулзалт, Үндэстнүүдийн Холбооны Австрали Улс

5 ДУГААР САРЫН 29-31

Бичил санхүүгийн төв (МФС) ээлжит чуулган, Бүгд Найрамдах Турк Улс

6 ДУГААР САРЫН 17-20

СХН-ийн Зүүн Европ Төв Азийн Зөвлөлийн Уулзалт

6 ДУГААР САРЫН 29

Азийн ИншурТек дээд уулзалт, Бүгд Найрамдах Сингапур Улс

7 ДУГААР САРЫН 24-26

Олон улсын хоршоодын зохицуулагчдын сүлжээ (ICURN)–ний ээлжит чуулган АНУ

9 ДУГААР САРЫН 9-13

СХН-ийн ээлжит Дэлхийн бодлогын форум, Руандагийн Бүгд Найрамдах Улс



Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IV байр.



+976-51-264444



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



Санхүүгийн зохицуулах хороо